

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА.....	2
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН.....	3
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	
1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	4-8
1.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт.....	9-13
1.3.Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	14-20
1.4.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт.....	21-28
1.5.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт.....	29-34
ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	
2.1.Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	35-39
2.2.Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	40-42
2.3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	43-50
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	
3.1.Байгууллагын ил тод байдал.....	51-58
3.2.Шилэн дансны хөтлөлт.....	59-67
3.3.Шударга байдлын түвшин.....	68-71
ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГТ ТУССАН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	
4.1.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт.....	72-84
ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ.....	85
Хавсралт 1: Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө	
Хавсралт-2: Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	
Хавсралт-3:Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт (журмын 4 дүгээр хавсралт)	
Хавсралт-4: Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт (журмын 9 дүгээр хавсралт)	
Хавсралт-5: Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт (журмын 11 дүгээр хавсралт)	
Хавсралт-6: Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд 2022 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан	

-оОо-

ТАНИЛЦУУЛГА

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго:

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлт, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх, гарсан дүгнэлт, зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар хавсралтын дагуу 4 бүлэг, 11 үзүүлэлтээр (Шударга байдлын түвшний үнэлгээ, Хэрэглэгчийн үнэлгээг хамааруулаагүй болно.) аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлт, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээний тайлан мэдээллийг холбогдох бодлогын хэлтсээс гаргуулан, хэрэгжилт мэдээлэлд дахин тодруулга хийх, хэрэгжилтийн үнэлгээг аргачлалын дагуу зөв үнэлэх үйл ажиллагааг гүйцэтгэн түүнд тулгуурлан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн бөгөөд бодлогын баримт бичгийг орон нутагт чанар, үр дүнтэй зохион байгуулах, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлт, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжилт үр дүнгийн талаар аймгийн удирдлага болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг үнэн зөв мэдээллээр хангах үндсэн чиг үүргийн дагуу зохион байгуулж ажиллалаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ, байгууллагын чиг үүргийн болон байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээний үзүүлэлтийн хүрээнд Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ болон байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт, ил тод байдал, шилэн дансны хөтлөлт, Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн мэдээлэлд үндэслэв.

Журамд заасны дагуу нэгдсэн үнэлгээг тооцохдоо бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох 5 үзүүлэлт нийт үнэлгээний 50,0 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох 3 үзүүлэлт 15,0 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох 3 үзүүлэлт 20,0 хувь, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ болох 1 үзүүлэлт 15,0 хувиар тус тус тооцсон болно.

Аймгийн Засаг дарга түүний Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг 2022 онд хүрсэн бодит гүйцэтгэлийг хүрвэл зохих зорилтот түвшинтэй харьцуулан үнэлсэн бөгөөд үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр 96,32 хувь буюу 4,8 оноотой дүгнэгдлээ.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР

Журмын 7 дугаар хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	91,1	0,5	
	2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	90,2		
	3.Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	91,0		
	4.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	90,2		
	5.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт	93,4		
	Дундаж	91,18		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	94,4	0,15	
	2.Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	97,4		
	3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	100,0		
	Дундаж	97,3		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдал	100,0	0,2	
	2.Шилэн дансны хөтлөлт	99,1		
	3.Шударга байдлын түвшин	-		
	4.Хэрэглэгчийн үнэлгээ	-		
	Дундаж	99,6		
Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт	97,2	0,15	
	Дундаж	97,2	14,58	
Ерөнхий үнэлгээ:		96,32	94,68	4,8

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

1.1. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ

Хяналт-шинжилгээ үнэлгээний зорилго, үндэслэл:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго нь төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад оршино.

Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2022 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд (www.unelgee.gov.mn) байршуулсан аймгийн Засаг даргад хэрэгжүүлж ажиллахаар үүрэг болгосон, даалгасан нийт 42 шийдвэрийн 129 заалтыг хяналтад авч Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.


Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлан мэдээллийг холбогдох бодлогын хэлтсээс гаргуулан, хэрэгжилт мэдээлэлд дахин тодруулга хийх, хэрэгжилтийн үнэлгээг аргачлалын дагуу зөв үнэлэх үйл ажиллагааг гүйцэтгэн түүнд тулгуурлан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн бөгөөд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг орон нутагт чанар, үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжилт үр дүнгийн талаар аймгийн удирдлага болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг үнэн зөв мэдээллээр хангах үндсэн чиг үүргийн дагуу зохион байгуулж ажиллалаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад хяналтад авсан 42 шийдвэрийн 129 заалтын 89 (69,0 хувь) нь бүрэн хэрэгжсэн буюу 100,0 хувийн үнэлгээтэй, 37 (28,7 хувь) нь хэрэгжих шатанд буюу 70,0 хувийн үнэлгээтэй, хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй заалт байхгүй, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 3 заалт (2,3 хувь) байгаа бөгөөд биелэлтийн дүнг дунджаар авч үзвэл 91,1 хувьтай буюу 4,55 оноотой үнэлэгдэв. (Жич:Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй нийт 3 заалтыг ерөнхий үнэлгээ гаргах заалтын тооноос хасаж тооцсон болно.)

Нийт хяналтад авагдсан шийдвэрийн 2021 оны жилийн эцсийн үнэлгээг 2022 оны жилийн эцсийн хүрсэн түвшинтэй харьцуулан харуулбал:

График 1.1




Үүнээс харахад тогтоол шийдвэрийн 2022 оны нийт хяналтад авсан шийдвэрүүдийн 69,0 хувь нь бүрэн хэрэгжиж үр дүнд хүрсэн, 28,7 хувь нь хэрэгжих шатанд буюу зохион

байгуулалтын үйл ажиллагаа хийгдэж, гол үр дүн нь гарсан, 2,3 хувь нь шинээр батлагдаж хяналтад авсан буюу 2023 оноос үр дүнг тооцож ажиллах шийдвэрийн заалтууд байна.

Нийт шийдвэрийн хяналтад авсан заалтуудыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн чиг үүргээр нь хариуцсан салбартаа хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулсан дүнг авч үзвэл:

График 1.2



Үүнээс харахад аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтсийн хяналтад авсан шийдвэрүүдийн хэрэгжилт 90-ээс дээш хувийн хэрэгжилттэй байгаа бөгөөд эдгээр шийдвэрүүдийн дийлэнх хувь нь нэг удаагийн буюу зохион байгуулалтын шинжтэй шийдвэрүүд тул бүрэн хэрэгжсэн байна. Харин Хууль, эрх зүйн хэлтэс, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн чиг үүрэгт хамаарах шийдвэрүүдийн хэрэгжилтийн дундаж 82,1-88,0 хувийн хэрэгжилттэй байгаа нь тухайн салбарт хэрэгжиж буй шийдвэрүүдийн дийлэнх хувь нь төсөв, санхүүгийн асуудлаас шууд хамааралтай байдгаас шалтгаалж зарим шийдвэрийн хэрэгжилт удаашрах, хүлээгдэхэд нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Нийт 42 шийдвэрийн 129 заалтыг шийдвэрийн төрлөөр биелэлтийн хувийг авч үзвэл:

График 1.3



Дээрх графикт үзүүлсэн тогтоол, шийдвэрийн заалтуудын хэрэгжилтийг нарийвчлан авч үзвэл Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Үндэсний аюулгүй

байдлын зөвлөлийн зөвлөмж 92,5-98,6 хувь байгаа нь бүрэн хэрэгжсэн буюу холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо хүрсэн үр дүнтэй байна. Харин Ерөнхийлөгчийн зарлиг 86,1 хувь, Засгийн газрын тогтоол 80,7 хувь, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 77,5 хувь, Засгийн газрын албан даалгавар 70,0 хувь байгаа нь хэрэгжих шатанд буюу зохион байгуулалтын арга хэмжээ авч, гол үр дүн гарсан байна гэж дүгнэж байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтаас хасах санал оруулсан шийдвэр, заалтын тоог 2022 оны жилийн эцсийн байдлаар авч үзвэл:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 7 шийдвэрийн 11 заалтыг хяналтаас хасах саналыг гаргасан байна. Үүнд:

Хүснэгт 1.1

д/д	Шийдвэрийн ангилал	Шийдвэрийн тоо	Заалтын тоо
1.	Монгол Улсын хууль	4	8
2.	Ерөнхийлөгчийн зарлиг	2	2
3.	Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	1	1

Тайлбар: Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтаас хасах саналд оруулж буй заалтуудын шалтгаан нөхцөл, агуулга, дэлгэрэнгүй танилцуулгыг Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгийн тайлангийн хавсралтаар гарган хүргүүлсэн болно.

Мөн Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (www.unelgee.gov.mn)-д байршуулсан Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгаврыг тухай бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулан холбогдох албан тушаалтанд үүрэг даалгаврын хэрэгжилтийг хариуцуулан үр дүнг тооцон долоо хоног тутамд хэрэгжилтийг тайлагнан ажиллалаа.

Дүгнэлт:

2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 42 шийдвэрийн 129 заалтын хэрэгжилтийг биелэлтийн хувиар авч үзвэл 100,0 хувийн биелэлттэй 89 заалт, 70,0 хувийн хэрэгжилттэй 37 заалт, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй 3 заалтыг тайлагнасан нь эхний хагас жилийн тайлангийн үр дүнтэй харьцуулахад бүрэн хэрэгжсэн шийдвэрийн заалт 36-аар өсөж, хэрэгжих шатанд байгаа шийдвэрийн заалт 43-аар, хэрэгжилт хангалтгүй шийдвэрийн заалт 12-оор, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй шийдвэрийн заалт 18-аар тус тус буурсан байна. Эдгээрээс харахад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн нь хэрэгжилтийн хугацаанаас хамааран тодорхой үр дүнгийн ахиц, өөрчлөлт гарч байгаагийн илрэл юм.

Хэрэгжилт хангалтгүй буюу 30,0 хувийн хэрэгжилттэй заалт 2021 онд 1 байсан бол 2022 онд хэрэгжилт хангалтгүй буюу удаашралтай заалт байхгүй байгаа нь шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр арга зүйн зөвлөмжийг тогтмол өгч, хяналтыг сайжруулсны үр дүн гэж дүгнэлээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллийн сан үүсгэн, хэрэгжилтийн явцыг сар бүр цахим системээр тайлагнан, хэрэгжилтийн тайланд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хэрэгжилт удааширсан, эрчимжүүлэх шаардлагатай ажлуудыг илрүүлэн, гүйцэтгэлийг сайжруулан ажиллаж байгаа нь тайлангийн чанарт эергээр нөлөөлсөн үзүүлэлт болж байна.

Сум, агентлагийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмжийг тухай бүр хүргүүлэн ажиллав. Зөвлөмжийн хүрээнд сум, агентлагууд гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт ирүүлсэн нь тухайн ажлыг үнэлэх нэг үзүүлэлт болгон дүгнэлээ. Тайлант онд сум, агентлагуудын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн тайлагналт, бүртгэл,

хяналтад авч буй байдалд арга зүйн зөвлөмж өгч ажилласнаар шийдвэрийн бүртгэл, хяналтад авч буй байдал, тайлагналт жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн тухай” 46 дугаар хуралдааны тэмдэглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 03 дугаар албан даалгаврыг боловсруулан батлав. Тус шийдвэрээр хэрэгжилт удаашралтай, гүйцэтгэл хангалтгүй байгаа шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх, бодит үр дүнг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг сайжруулах талаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга, сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсийн дарга нарт үүрэг болгосноор хэрэгжилт удаашралтай, гүйцэтгэл хангалтгүй байгаа шийдвэрийн тоо буурсан үзүүлэлттэй байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2021 оны хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжөөр хэд хэдэн чиглэлээр анхаарвал зохих асуудлыг хөндсөн бөгөөд тус зөвлөмжийн мөрөөр гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг эрчимжүүлж ажилласнаар тодорхой үр дүнгүүд гарсан ба үр дүнг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тайлангийн танилцуулгад тусган тайлангийн хавсралтаар хүргүүлэн ажилласан.

Дүгнэлт, зөвлөмжид хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр нэг шийдвэрийн заалтыг онцолсон бөгөөд энэ нь Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 24 дүгээр хуралдааны тэмдэглэлийн “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлэн шинэчлэх, тодотгох ажлыг 2022 онд бүрэн дуусгаж, батлуулах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллах”-ыг даалгасан шийдвэр байна. Уг хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх ажлын даалгаврыг боловсруулж 2022 оны аймгийн төсөвт 150,0 сая төгрөгийг тусган аймгийн Орон нутгийн өмчийн газар зөвлөх үйлчилгээний тендерийг 2 удаа зарласан боловч тендер оролцогч мэргэжлийн байгууллагуудын маргааны улмаас тендер цуцлагдан улмаар 2022 онд орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх хөрөнгийг буцаан татсан бөгөөд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зардлыг 2024 оны улсын төсөвт тусгуулахаар ажиллаж байна.

Аймгийн Засаг даргад үүрэг болгосон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, гарсан үр дүн, үр нөлөөг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хугацаанд нь Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (www.unelgee.gov.mn)-д байршуулж, тайлагнаж хэвшүүлсэн байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зөвлөмж болон бодлогын хэлтсүүдийн саналуудыг үндэслэн бүрэн хэрэгжсэн, хэрэгжилт тогтмолжсон, нэг удаагийн шинжтэй 11 заалтыг цахим сангийн хяналтаас хасуулах санал хүргүүлэн ажилласан байна.

Зөвлөмж:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлангийн чанар, анхаарах асуудлууд:

-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, мөн төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллах талаар бодлогын хэлтэс болон сум, агентлаг, төсвийн байгууллагуудад чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

-Тайланг хэтэрхий нуршсан, үр дүнг бус үйл ажиллагааг дэлгэрэнгүй тайлагнах байдал давтагдсаар байгаа тул тайланг график, хүснэгт ашиглаж, үр дүнг товч тодорхой, ойлгомжтой тайлагнах;

-Тухайн шийдвэрийн суурь судалгаа, холбогдох мэдээллийн санг баяжуулах, судалгаа, тоо баримтад үндэслэн товч тодорхой тайлагнах;

-Шинээр хяналтад авсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллах, мөн цаашид эрчимжүүлж ажиллах шийдвэрийн заалтуудын талаар хамаарах сум, байгууллагуудад зөвлөмж хүргүүлэн, үүрэг чиглэл өгч, хяналт тавьж ажиллах.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

1.2.ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан аймаг, орон нутагт хамаарал бүхий 5 бүлэг, 63 зорилт, 117 арга хэмжээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу дүгнэж, 2022 оны хэрэгжилтийн дундаж 90,2 хувьтай байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн www.unelgee.gov.mn цахим санд 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр байршуулж, баталгаажуулав.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргахдаа Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 203 дугаар тогтоолд орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхээр заасан арга хэмжээнд үндэслэсэн болно.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг бүлэг тус бүрээр заалтын үнэлгээний дүнг нэгтгэн харуулвал:

Хүснэгт 1.2

№	Бүлэг	Хувь							Арга хэмжээ	Дундаж хувь
		Тодорхой шалтгааны улмаас үнэлээгүй	Үр дүнгүй (0 хувь)	Эрчимжүүлэх шаардлагатай (30 хувь)	Эрчимжүүлэх шаардлагатай (50 хувь)	Тодорхой үр дүнд хүрсэн (70 хувь)	Тодорхой үр дүнд хүрсэн (90 хувь)	Үр дүнтэй (100 хувь)		
1	Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	-	-	-	-	-	-	5	5	100,0
2	Хүний хөгжил	-	-	-	1	2	11	24	38	94,2
3	Эдийн засаг	5	-	7	4	3	5	13	37	74,0
4	Засаглалын бодлого	-	-	-	1	-	7	7	15	92,0
5	Ногоон хөгжлийн бодлого	1	-	1	-	2	6	12	22	90,9
<i>Нийт</i>		6	-	8	6	7	29	61	117	90,2

Үнэлгээний дүнгээс харахад Эдийн засаг болон Ногоон хөгжлийн бодлого бүлгийн нийт 6 заалтын хэрэгжилтэд үнэлгээ өгөөгүй, нийт 8 заалт хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай буюу 30,0 хувийн хэрэгжилттэйгээр үнэлэгдсэн байгаа бөгөөд эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө шийдвэрлэгдээгүй, орон нутгаас бие даан шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдлаас шалтгаалсан байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд орон нутгийн дунд хугацааны хөгжлийн баримт бичиг болон аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд холбогдох зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлж ажилласан байна.

Хөтөлбөрийн хүрээнд үр дүнтэй хэрэгжиж байгаа зорилт, хэмжээг тоймлон авч үзвэл:

1. Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Өвөрхангайд үйлдвэрлэв” худалдааны төвийг Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын аймаг дахь салбар танхим менежментийн гэрээгээр ажиллуулан, орон нутгийн үйлдвэр, худалдаа эрхлэгчдийг бизнесийн зөвлөгөө, мэдээллээр хангаж, 93 иргэн, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн 600 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг зуучлан, борлуулж, байгуулагдсанаас хойш нийт 451,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Made in Uvurkhangai олон улсын худалдааны Вебсайт шинээр хийж, 2,7 сая төгрөгийн борлуулалт хийгдлээ. Хархорин суманд “Хархоринд үйлдвэрлэв” борлуулалтын цэг ашиглалтад орж, 19 иргэн, аж ахуйн нэгжийн 56 төрлийн бараа бүтээгдэхүүнийг борлуулж, “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл болон орон нутгийн төсвийн 79,0 сая төгрөгийн хөрөнгөөр Хужирт суманд мөн борлуулалтын цэг байгуулагдсан.

2. Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлэх зорилтын хүрээнд аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний операторын үйлчилгээ жигдэрч, тайлант хугацаанд 19 сумын Засаг даргын Тамгын газрын оператор ажилтнаар дамжуулан 243 төрлийн 11324 цахим үйлчилгээг үзүүлж, 16,2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэв. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, “И-Монгол” академитай хамтран нутгийн захиргааны 15 байгууллагын 67 үйлчилгээг E-Mongolia системд нэвтрүүлж ажилласан байна.

3. Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулах зорилтын хүрээнд “Арвайхээр тохижилт үйлчилгээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар “Хаягдал хуванцар дахин боловсруулах” үйлдвэр байгуулан үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй Арвайхээр сумын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслөөр тус суманд пүү болон хоёрдогч түүхий эд хүлээн авах 5 цэгийг шинээр байгуулав. Уг төслийн хүрээнд бичил тэтгэлэг зарлагдаж, “Эрүүл амьдрал”, “Үнсэн блок үйлдвэрлэх”, “Хаягдал сүүний савыг дахин ашиглах” зэрэг төслүүдэд тус бүр 5000 ам.доллар, “Арвайхээр тохижилт үйлчилгээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын “Арвайхээр суманд ногоон ажлын байр бий болгох, хаягдал хуванцар сав, гялгар уутыг дахин боловсруулж, хашааны шон, нүхэн жорлонгийн кольцо зэрэг нийгмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх” төсөлд 15,000 ам.долларын тэтгэлэгийг тус тус олгосон байна.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг айл өрхүүдэд хэвшүүлж, дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх ажлын хүрээнд 13 суманд хоёрдогч түүхий эд хүлээн авах 28 цэг байгуулагдаж, 301,8 тн дахивар хаягдлыг цуглуулан аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг “Эко цэнэ”, “Цэмцгэр” төвүүд болон Улаанбаатар хот руу нийлүүлжээ. Есөнзүйл, Гучин-Ус, Баян-Өндөр, Уянга, Бүрд, Арвайхээр сумдууд 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн 69,0 сая төгрөгийн хөрөнгөөр хоёрдогч түүхий эдийг нягтруулах пресслэгч төхөөрөмжийг худалдан авснаар аймгийн хэмжээнд 12 сум, 19 пресслэх төхөөрөмжтэй болсон байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн орон нутагт хамааралтай хэрэгжилт хангалтгүй буюу удаашралтай байгаа зорилт, арга хэмжээний талаар:

1. Дулааны станцын дэд бүтцийг байгуулах, дулаан түгээх сүлжээг шинэчлэх, шинээр барих (3.5.3.5) арга хэмжээний хүрээнд Арвайхээр хотын төвд дулааны станцын дэд бүтцийг байгуулах 110/35/10 кВ-ын Арвайхээр дэд станцын 10кВ-ын хаалттай хуваарилах гаргалгааны зураг, дулаан түгээх сүлжээг шинэчлэх ажлын зураг төсөл бүрэн хийгдэж улсын төсөвт тусгахаар санал хүргүүлсэн боловч “Төрийн хэмнэлтийн тухай” хуулиар хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн.

2. Хужирт-Арвайхээр чиглэлийн 56 км хатуу хучилттай авто замыг барих (3.6.1.8) хүрээнд Арвайхээр-Хужирт сумдыг холбох 43,3 км урттай хатуу хучилттай авто замыг шинээр барих зураг төсөв хийгдэж, улсын төсөвт тусгахаар санал хүргүүлсэн боловч “Төрийн хэмнэлтийн тухай” хуулиар хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүссэн.

3. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Онгийн голын 166 у/м төмөр бетон гүүр барих (3.6.1.10) ажлын хүрээнд Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалтын төслөөр хэрэгжсэн Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 57,56 км авто замын их засвар шинэчлэлийн ажилд Онгийн голын 166 у/м төмөр бетон гүүрийн их засвар хийгдэхээр төлөвлөсөн боловч засварлах хөрөнгө нь хүрэлцэхгүй болж тус гүүрийн засварыг хийх боломжгүй болсон. Уг гүүрийн их засварын тооцоог шинээр хийж 11,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийн тооцоо гарсан байна.

4. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах (3.7.4.4) арга хэмжээний хүрээнд аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын зардлыг 2022 оны орон нутгийн төсөвт 150,0 сая төгрөг суулгаж, тендер шалгаруулалт зарласан боловч хөрөнгө татагдсан зэрэг хөрөнгийн эх үүсвэртэй холбоотойгоор хэрэгжилт хангалтгүй арга хэмжээнүүд байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн ХЭГ/1645 дугаартай албан бичгээр ирүүлсэн аймгийн 2021 оны үйл ажиллагааг дүгнэсэн үзүүлэлт тус бүрээр гаргасан дүгнэлт, зөвлөмжид тусгагдсан орон нутагт хамаарал бүхий Засгийн үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт үр дүнгийн тайланд өгсөн дүгнэлтээр хэрэгжилт хангалтгүй болон удаашралтай байгаа 5 (3.7.9.8, 3.7.12.4, 5.1.4.1, 5.1.11.2, 6.2.13.1) арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах чиглэл өгөгдсөн байна. Зөвлөмжийн дагуу дараах ажлуудыг гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажилласан. Үр дүн хангалтгүй гэж үнэлэгдсэн арга хэмжээний хэрэгжилтийг тус бүрээр авч үзвэл:

Хүснэгт 1.3.

Д/д	Заалт	Хэрэгжилт, үр дүн
1.	3.7.9.8. Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулна.	Төрийн албан хаагч, залуу гэр бүл зэрэг зорилтот бүлэгт зориулсан түрээслээд өмчлөх 25 айлын орон сууц барих ажлыг эхлүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,0 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч, Covid-19 цар тахлын улмаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 34 дүгээр тогтоолоор зориулалтыг өөрчилсөн. Хужирт сумын төрийн албан хаагчийн 9 айлын орон сууцны зураг төсвийг “Арвай порект” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж хүлээн авсан. Арвайхээр суманд баригдах 60 айлын түрээсийн орон сууцны холболтын зураг төслийг “Цесда” ХХК-иар гүйцэтгүүлэхээр санал хүргүүлсэн байна.
2.	3.7.12. Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам	Арвайхээр сумын 21 км урттай үерийн далан сувгийн зураг, төслийг “Хидро инженеринг” ХХК-иар хийж гүйцэтгүүлж, зураг, төслийг хүлээн авсан. Арвайхээр суманд Дэлгэрэх голын голдирол шулуутгах ажлын

	сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	хүрээнд 820 м далан сувгийн ажлыг орон нутгийн төсвийн 178,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэв. Арвайхээр хот болон Уянга сумын үерийн хамгаалалтын байгууламжийн ажлын зураг төслийг Улаанбаатар хотын “Хидро инженеринг” ХХК-аар гүйцэтгүүлсэн. Хархорин сумын Мойлт ба Арцатын гэр хорооллыг үерээс хамгаалах байгууламжийн ажлын зургийг “Мон хидро” ХХК хийж, ажлын гүйцэтгэгчээр “Гүн чимэгтэй” ХХК шалгарч ажлаа эхлүүлээд байна.
3.	5.1.4.1.Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ.	Азийн хөгжийн банк болон орон нутгийн төсвийн 480,0 сая төгрөгийн санхүүжилтээр “КА-9100-МОН” төслийн хүрээнд Арвайхээр сумын 13 багийн 283 өрх тус төсөлд хамрагдаж сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон. 2021 онд голын хамгаалалтын бүс болох Онги, Дайргын голын орчимд стандартын шаардлага хангасан 3 ширхэг хөрсөнд үл нэвчих, сайжруулсан нийтийн ариун цэврийн байгууламж, хог хуримтлуулах бункер хийж байршуулсан. 2022 онд Өвөрхангай аймгийн хэмжээнд гэр хорооллын айл өрх болон албан байгууллагууд өөрсдийн санаачилгаар нүхэн жорлонгоо сайжруулж, хөрсөнд үл нэвчих 1043 ширхэг ариун цэврийн байгууламжийг шинээр байгуулсан. Аялал жуулчлалын эвент арга хэмжээнд зориулж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 38,0 сая төгрөгөөр 17 суултуур бүхий 3 ширхэг зөөврийн эко ариун цэврийн байгууламж худалдан авч эвент арга хэмжээнүүдэд ашиглаж байна.
4.	5.1.11.2.Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулна.	2021-2022 онд орон нутаг болон хувийн хэвшлийн хөрөнгөөр 13 суманд нийт 62 булаг, шанд, рашааны эхийг хашиж хамгаалан нутгийн иргэдэд хариуцууллаа. Нарийнтээл сумын “Их булаг” хэмээх газарт хөв цөөрөм байгуулах зураг төсөл боловсруулах ажлыг усны мэргэжлийн байгууллага “Гидрофонтан” ХХК 2022 оны 6-9 дүгээр сард гүйцэтгэж хүлээлгэн өгсөн бөгөөд хөв цөөрөм байгуулах ажлын төсөвт өртөг болох 396,8 сая төгрөгийн санхүүжилтийг “Баянтээг” ХК-ийн хөрөнгөөр 2023 онд хийлгүүлэхээр төлөвлөсөн.
5.	6.2.13.1.Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх” цогц төлөвлөгөөний хүрээнд аймгийн хэмжээнд нийт 44,5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1407 иргэн, аж ахуйн нэгжид олгосон байна. Мөн Хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээлд 1365 малчин өрхөд 10,5 тэрбум төгрөг, газар тариалан эрхлэгч 6 иргэн, аж ахуй нэгжид 175,0 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл хүссэн 3 аж ахуйн нэгжийн 353,0 сая төгрөгийн төслийн зээлийн хүсэлт дэмжигдсэн. “Сум хөгжүүлэх сан”-гаас 15 суманд нийт 223 иргэн, аж ахуйн нэгжид 1,6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Мөн Зээлийн батлан даалтын сангаас 5 аж ахуйн нэгжид 1,2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж, 562,3 сая төгрөгийн батлан даалтад хамруулсан байна.

		Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Бат-Өлзий суманд хэрэгжүүлж буй "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл"-ийн хүрээнд Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутаг тэдгээрийн орчны бүсээс сонгогдсон 35 малчин өрхөд Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангаас 286,8 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. Аймгийн хэмжээнд 2020 онд нийт 1,3 тэрбум төгрөгийн зээл олгогдож байсан бол 2021-2022 онд 3044 иргэн, аж ахуйн нэгжид 58,6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн байна.
--	--	---

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх орон нутагт хамаарал бүхий арга хэмжээний төлөвлөгөөг нарийвчлан тооцож, аймгийн дунд хугацааны хөтөлбөр, хөгжлийн төлөвлөгөөнд тусган, төрийн байгууллагын удирдлагуудад эрчимжүүлэн ажиллах үүрэг чиглэл өгч, үр дүнг тооцон ажиллав.

Зөвлөмж:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүдэд:

Дараах зөвлөмжийн дагуу тайланг бэлтгэх, үр дүнг тооцох шаардлагатай байна. Үүнд:

-Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс хэрэгжилт нь удааширч байгаа зорилт, арга хэмжээний судалгааг тооцоолол, тоон мэдээнд тулгуурлан нарийвчлан гаргаж, холбогдох яам, агентлагуудтай хамтран хэрэгжүүлэх, тэднээс туслалцаа дэмжлэг авах талаар идэвх санаачилгатай ажиллах;

-Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг тайлагнахдаа гарсан үр дүнг нотлох баримтын хамт тайланд тусгаж байх;

-Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг холбогдох байгууллага, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангуулж байгаа эсэхэд дүгнэлт хийж, тогтмол хяналт тавьж ажиллах;

-Дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг зөв төлөвлөх, зорилтот түвшинг ерөнхий байхаас татгалзах, тайлан тодорхой бүрэн байх, тухайн арга хэмжээ хэзээ ямар хугацаанд зохион байгуулагдсан талаар тодорхой тусгах, тайлагналтыг ойлгомжтой товч тодорхой, чанар, тоон үзүүлэлттэй арга хэмжээг суурь түвшинтэй харьцуулан загвар аргачлалын дагуу тайлагнахад анхаарч ажиллахыг зөвлөж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

1.3. АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг 5 бодлогын хүрээнд 19 чиглэл, 46 зорилт, 191 арга хэмжээ тусган хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүнг 91,0 хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дүгнэлээ.

Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилт, салбарын чиглэлээр хүснэгтлэн үзүүлвэл:

Хүснэгт 1.4.

Хөгжлийн бодлого (салбараар)	Арга хэмжээний тоо	Дундаж үнэлгээ
1. Хүний хөгжил	94	89,8
2. Эдийн засаг	44	90,6
3. Засаглалын бодлого	29	90,0
4. Ногоон хөгжил, байгаль орчин	17	86,4
5. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван түүлах бодлого	7	100,0
Нийт	191	91,0

Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан бодлого, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг тоймлон авч үзвэл:

Хүний хөгжлийн бодлогын хүрээнд:

Төв халхын уртын дууны өв санг хамгаалах, шавь сургалтыг хөгжүүлэх, сурталчлан түгээн дэлгэрүүлэхээр “Уртын дуугаа дээдлэн дэлгэрүүлцгээе” нэг сарын аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулав. Аяны хүрээнд Оломгүй далай, Нарийн сайхан хээр, Хүрэн толгойн сүүдэр зэрэг дууг иргэд олон нийтэд сурталчлан 1500 гаруй хүүхэд, залуучууд, иргэдэд уртын дуу зааж, соёлын өвийг сурталчилж байна.

Хүүхэд, залуучуудын авьяас билгийг нээх, бүжгийн урлагийг орон нутагт хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэхээр “Хаврын баяр” наадмыг цэнгээнт, спорт, нийтийн, орчин үеийн, ардын бүжгийн нийт 5 төрлөөр зохион байгууллаа. Төрөл тус бүрд бага, дунд, есвөр үе, залуучууд, ахмад гэсэн насны ангиллаар 800 гаруй хүн өрсөлдөж, 128 оролцогчдыг шагнаж урамшуулав.

Хүүхэд, багачуудыг төрөлх аймаг, сум орон нутгийнхаа түүх, соёл, өв уламжлал, бахархалт хүмүүсийн түүхэн замнал, байгалийн болон соёлын дурсгалт газруудыг судлан мэдүүлж, нутаг усаа хайрлан хамгаалах, уламжлалт ёс заншлаа хүндлэн дээдэлдэг иргэн болгон төлөвшүүлэхээр “Миний Өвөрхангай” сарын аяныг зохион байгуулж, 1000 гаруй багш, сурагч идэвхтэй оролцож, шинэ бүтээлийн уралдаанд 100 гаруй бүтээл, үйл ажиллагаа, хэрэглэгдэхүүний уралдаанд 400 гаруй бүтээлээр оролцсоныг /<http://uv.edu.mn> сайтад “Өвөрхангайн магтаалыг хэн сайн дуулах вэ?” уралдааны бүтээлүүдийн хамтаар “Миний Өвөрхангай” цэс үүсгэн байршуулж, олон нийтийн хүртээл болгоод байна.

Хүүхэд багачуудыг номоор дамжуулж хүмүүжүүлэх чиглэлээр “Аав, ээжтэйгээ уншигч”, “Бүтээлч уншигч” сэдэвт соёл, нөлөөллийн аян зохион байгуулж тус аянд 31 сургуулийн нийт 500 гаруй эцэг эх, 3200 гаруй сурагч хамрагджээ. Аяны үр дүнд номын сангийн уншигчдын тоо 13,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дотуур байранд болон сургуулийн орчинд сурагчдыг чөлөөт цагаараа ном унших, уншсан номынхоо утга, агуулгаар хэлэлцүүлэг өрнүүлэх, ном солилцоо арга хэмжээ, номын булан байгуулах ажлуудыг санаачлан хэрэгжүүлэв. Тухайлбал: Бат-Өлзий сумын ерөнхий боловсролын сургуулийн багш нар “Номтой нөхөрлөө” цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, тус арга хэмжээний үр дүнг судалгааны бүтээл болгон боловсруулж, улмаар 2022 оны эрдэм шинжилгээний бүтээлийн улсын уралдаанд оролцож дэд байр эзэлсэн

амжилтыг үзүүллээ. Мөн Хархорин, Уянга, Хайрхандулаан, Баян-Өндөр, Жаргалант, Сант, Арвайхээр сумын 1, 4, Мэргэд, Тэмүүлэл-Эрдэм сургуулиуд сургууль, дотуур байрны орчинд ном унших орчин нөхцөлийг шинээр бүрдүүлж өгсөн байна.

Эрүүл мэндийн чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дэргэд болон Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт “Эрүүл мэндийг дэмжих төв” байгуулагдан эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, хорт хавдрыг эрт үед нь оношлох, илрүүлэх үзлэгийг цогцоор үзүүлж, 5734 иргэнийг үзлэгт хамруулсан үзүүлэлтээр улсад тэргүүлэв.

Эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн, үе тэнгийн сургагч, бүлгүүдийг сургаж, чадавхжуулах, идэвхжүүлэх замаар эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд бүх нийтийн оролцоог нэмэгдүүлэх, айл өрх, албан байгууллагуудад эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлэхээр 2 сум, 5 байгууллага, 239 айл өрх, 7500 гаруй иргэнийг мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган, үе тэнгийн сургагч багшаар 80 сурагчийг бэлтгэлээ. Тайлант онд Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн цаг товлох үйлчилгээг өргөжүүлж 1664 иргэн E-mongolia, 70323212 утсаар 52300 иргэн, цахимын шууд үйлчилгээгээр 46200 иргэн үйлчлүүлсэн байна.

Эдийн засгийн бодлогын хүрээнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газраас Монгол банкт хамтран зохион байгуулсан нийт 28 удаагийн 12 төрлийн өрхийн санхүүг нэмэгдүүлэх, хадгаламж, хуримтлал бий болгох сургалт, сурталчилгаа, төрөл бүрийн уралдаан тэмцээн, теле нэвтрүүлэг, нээлттэй хаалганы өдөрлөг, цахим болон танхимын сургалт, сурталчилгаа зэрэг арга хэмжээ зохион байгуулж 100 гаруй байгууллага, 2,6 мянган иргэн хамрагдсан нь өмнөх оноос 2,2 дахин өссөн. Нийт 81,9 мянган иргэн 169,1 тэрбум төгрөгийн хадгаламж эзэмшиж байна.

Зураг 1.1

Аймгийн хэмжээнд улсын төсвийн 501,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар инженерийн хийцтэй гүн өрмийн 20 худаг, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Сант суманд 3 худаг гаргаж бэлчээрийн усан хангамж 34,5 мянган га-аар нэмэгдээд байна.



Зураг 1.2



Орон нутгийн хөгжлийн сан болон “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн 50 хувийн хөрөнгө оруулалтаар Бат-Өлзий, Баян-Өндөр, Төгрөг, Нарийнтээл, Есөнзүйл сумдад 80,0 сая төгрөгийн санхүүжилтээр 50 тонны зоорь, Богд, Баруунбаян-Улаан сумдад 55,0 сая төгрөгийн санхүүжилтээр 30 тонны зоорь тус тус ашиглалтад орлоо.

Мөн Тайваны хүүхдийг ивээх сангийн хөрөнгө оруулалтаар “Өрхийн тариалан бизнес хөгжил” төрийн бус байгууллага Тарагт, Уянга, Зүүнбаян-Улаан сумдад 50м² багтаамж бүхий нарлаг хүлэмж ашиглалтад оруулав.

Арвайхээр, Хархорин сумдад улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 1,15 км урттай хатуу хучилттай авто зам, явган болон дугуйн зам, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн хамт ашиглалтад орж, иргэдийн аятай тухтай амьдрах орчин нөхцөл сайжирлаа.

Зураг 1.3



Бат-Өлзий, Уянга, Хархорин, Богд, Хужирт, Зүүнбаян-Улаан, Гучин-Ус, Өлзийт сумдын 17 байршилд Юнител ХХК үүрэн холбооны сүлжээ, Уянга, Баянгол, Өлзийт, Хужирт, Тарагт, Хархорин, Бүрд, Арвайхээр, Зүүнбаян-Улаан сумдын 10 байршилд Мобиком ХХК үүрэн холбооны сүлжээг тус тус өргөтгөж малчид болон суурин газрын хэрэглэгчид гэрээсээ шууд холбогдох нөхцөл бүрдээд байна.

Зураг 1.4

Арвайхээр сумын 10, 11 дүгээр багийн гэр хорооллолд 4344 метр цэвэр, 2980 метр бохир усны шугам сүлжээний холболтын ажлыг улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хийж, 400 гаруй айл өрх холбогдох боломжтой болж иргэдийн аятай тухтай амьдрах орчин нөхцөл бүрдээд байна.



Засаглалын бодлогын хүрээнд:

Тайлант хугацаанд 60 төрийн албан хаагч ёс зүйн зөрчил дутагдал гаргасан талаар гомдол ирүүлснээс 3 албан хаагчтай холбоотой гомдлыг судалж үзэхэд ёс зүйн зөрчил гаргасан үндэслэл тогтоогдоогүй байна. Төрийн албаны ангиллаар авч үзвэл төрийн үйлчилгээний 53, төрийн захиргааны 4 албан хаагч байна. Ёс зүйн зөрчлийг төрлөөр нь авч үзвэл харилцаа хандлага, ёс зүйн зөрчилтэй холбоотой 22, ажлын хариуцлага алдсан, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн 17, ажил тасалсан 6, ажлын цагаар, ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэсэн 11, дүрэм, журам зөрчсөн 1 албан хаагч байна. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний ёс зүйн дүрмийн хүрээнд ёс зүйн зөвлөлөөс 13 албан хаагчид уучлал хүсэх, 32 албан хаагчид сануулах дүгнэлт гаргасан бол 3 албан хаагч дүрэмд заасны дагуу сайн дураараа албан тушаалаас чөлөөлөгдсөн. Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, багшийн ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журмын дагуу 9 албан хаагчид сануулах, цалин буруулах хариуцлага хүлээлгэсэн.

Орон нутгийн 256,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 112 багийн Засаг дарга нарыг зөөврийн компьютероор хангаж, улсын төсвийн 150,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын тоног төхөөрөмжийн шинэчлэл"-ийн ажлыг хийж, ажиллах нөхцөлийг сайжирууллаа.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу төрийн байгууллагын цахим шууданг албан харилцаанд ашиглаж хэвшлээ.

Зураг 1.5

Нутгийн захиргааны 15 байгууллагын 67 үйлчилгээг E-Mongolia системд нэвтрүүлж, 184 үйлчилгээ үзүүлээд байна. Цахим системд шилжсэн төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, иргэдэд төрийн үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай авах нөхцөл, боломжийг бүрдүүлэх зорилгоор орон нутгийн 70,0 сая төгрөгийн хөрөнгөөр 15 суманд киоск машин суурилуулж цаг хугацааны болон эдийн засгийн бодит хэмнэлтийг бий болголоо.



Хангайн бүсийн Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Хужирт, Хархорин, Уянга сумдын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнээс хээрийн нэгдсэн дадлагад оролцох бүрэлдэхүүнийг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нартай хамтран сонгон авч томилгоот үүрэг гүйцэтгэх бэлтгэлийг хангуулан 09 дүгээр сарын 02-09-ний хооронд томилгоот бүрэлдэхүүнтэй хээрийн дадлага, үзүүлэх сургуулийг Өвөрхангай аймгийн Хужирт сумын Цагаан залаа зуслангийн районд зэвсэг, техниктэйгээр зохион байгуулж явуулав.

Зураг 1.6



Ногоон хөгжил, байгаль орчны бодлогын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2022 оныг “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах жил” болгон зарласан.

Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр: Бүх сумдад соёл амралтын болон цэцэрлэгт хүрээлэнгүүдийг шинээр байгуулах, өргөтгөн шинэчлэх ажлыг зохион байгуулав.

Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсэд 12 га талбай бүхий “Их Монгол” цэцэрлэгт хүрээлэнг байгуулж, хашаажуулан 14,0 мянга орчим мод тарьж, “Залуус”, “Моби гарден”, “Өлзийт овоо” зэрэг бичил цэцэрлэгт хүрээлэнгүүд байгуулаад байна.

Хархорин суманд хүүхдийн паркийн 2,3 га газрын зураг төсвийг хийлгэн хашаажуулж, Хужирт, Баянгол, Сант, Өлзийт сумд бичил цэцэрлэгт хүрээлэн шинээр байгуулж, бусад сумд цэцэрлэгт хүрээлэндээ нэмж мод бут тарих, тохижуулах ажлууд хийгдэж, бичил ногоон байгууламж 13 байгуулагдлаа.

Төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ өмнөх оны суурь түвшингээс 31 га талбайгаар нэмэгдэж, нийт 176 га болоод байна.

График 1.4



Зураг 1.7

Тайлант онд орон нутагт мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн чадавхыг бэхжүүлэхээр хангай, тал хээр, говиор бүсчилэн Арвайхээр цэцэрлэгжилт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, “Сум дундын ой анги”, “Өгөөмөр шунхлай”, “Батцэцэрлэгжилт”, “Өв-эхлэл өнгө”, “Их говийн төгөл” ХХК зэрэг 6 аж ахуйн нэгж, байгууллагад 216,0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс олгосон. Үүний үр дүнд 2021 онд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн мод үржүүлгийн 10 газарт 15 нэр төрлийн нийт 327,9 мянган тарьц, суулгац ургуулж байсан бол, 2022 онд энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх 11 аж ахуйн нэгж, иргэн нэмэгдэж, мод үржүүлгийн 21 газарт 18 нэр төрлийн 2,0 сая орчим тарьц суулгац ургуулж байна. Үүнд 2 настайгаас дээш буюу 2023 онд ойжуулалт цэцэрлэгжүүлэлтэд шилжүүлэх тарьц суулгац 340,0 мянга орчим байгаа бөгөөд 2024 оноос эхлэн жил бүр 1200,0 мянгаас дээш тооны тарьц суулгацыг нийлүүлэх боломж бүрдээд байна.



Агро ойжуулалт, авто зам дагуу ногоон зурвас байгуулав.

Зураг 1.8

Хархорин суманд газар тариалан эрхэлдэг 16 аж ахуйн нэгж 10 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж, 16,0 мянган мод, Төгрөг сумын Мазарт 6 га талбайг хашиж агро ойжуулалт хийж, 1200 ширхэг мод тус тус тарьсан. Арвайхээр суманд улсын чанартай А301 авто замын дагуу 2,5 км урт, 15 метр өргөнтэй хамгаалалтын хашаа барьж, 3400 ширхэг мод, Хужирт сумын Рашаан сувиллын орчим “Жем-Хужирт” ХХК, Хужирт рашаан сувилал ХХК 800 метр ойн зурвас, “ӨВ-А33А” ТӨХК Бүрд сумын



Зураг 1.9.



Шариланд “Алтан шар зам” төгөл байгуулж, 1000 ширхэг мод тарьж, улсын төсвийн хөрөнгөөр газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд Баруунбаян-Улаан суманд элсний нүүлтээс хамгаалах 8 га ойн зурвас, нийт агро ойжуулалт 12,4 га, авто зам дагуу 3,3 км ногоон зурвас байгуулаад байна.

Тайлант онд бүх нийтийн хог цэвэрлэгээ болон төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг ангилан ялгах нийтийг хамарсан ажлын хүрээнд 400, ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа, модны нүх ухах ажилд 10 хоногийн хугацаатай 500 иргэнийг тус тус түр ажлын байраар ханган ажиллуулав. Сумд мод тарих

газрын усалгаа, арчилгаа, хамгаалалтыг хариуцан ажиллах 24 хүнийг Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоонд багтаан гэрээгээр болон ажил үүрэгт өөрчлөлт оруулах, хавсран гүйцэтгэх байдлаар шийдвэрлэж, Арвайхээр, Хархорин сумд ногоон байгууламж, тохижилт үйлчилгээ хариуцсан байгууллагад усалгаа, арчилгаа хариуцсан 30 гаруй түр орон тооны ажилтан ажиллуулж байна.

Зураг 1.10

Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:

Гэр хорооллын айл өрхүүдийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг идэвхжүүлж, хог хаягдлын менежментийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “Өнгө нэм” төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хог хаягдлыг ангилан ялгах, хадгалах зориулалт бүхий хогийн савны жишиг загварыг 2 төрлөөр буюу гэр хороолол болон орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар гаргаж, Арвайхээр сумын 1383 өрх буюу нийт өрхийн 14,7 хувь ангилан ялгах хогийн савтай болж, хуванцар сав ангилах 25 ширхэг, дахивар болон энгийн хог хаягдал ангилах 14 ширхэг, хуванцар, цаас, бусад гэсэн ангиллаар 23, нийт 62 ширхэг хогийн савыг шинээр хийж, нийтийн эзэмшлийн зам, талбайд байршууллаа.



Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Онги-Тааз голын сав газрын захиргаа, Зэвсэг хүчний 256 дугаар ангитай хамтран аймгийн хэмжээнд нийт 161 уст цэг болон гадаргын усны ойр орчмыг цэвэрлэх ажлыг 2 удаа зохион байгуулж, Орхон, Онги, Таац, Дайрга, Ар-Агуйн гол, Найман нуур, Ногоон нуур, Таацын цагаан нуур, Хүрэмт нуур орчмын хог хаягдлыг цэвэрлэж, нийт 85,1 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгүүдэд хүргэж ажиллав.

Төвлөрсөн хогийн цэгээ Хайрхандулаан, Бүрд, Баян-Өндөр, Төгрөг сумд шинээр хашаажуулж, Гучин-Ус, Есөнзүйл сумд камержуулснаар аймгийн хэмжээнд 12 сумын төвлөрсөн хогийн цэг хашаатай, 6 сум хяналтын камертай болоод байна. Мөн сумд аюултай хог хаягдал буюу эмнэлгийн хог хаягдлыг шатаах, устгах цэгийг төвлөрсөн хогийн цэгүүд дээр байгуулж, аймгийн хэмжээнд төвлөрсөн хогийн цэгийн нийт талбайн хэмжээ 50,3 га болж өмнөх оноос 9,9 га талбайгаар буурсан.

“Баянтээг түлш” орон нутгийн өмчит ХХК 2022 онд 380 тн шахмал түлш үйлдвэрлэж, Арвайхээр сумын 6 багийн гэр хорооллын 700 гаруй айл өрхийг шахмал түлшээр хангаж байна. Тус үйлдвэрт Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 2,0 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлэн, үйлдвэрийн өргөтгөл, олон үйлдэлт зуух, хатаалгын төхөөрөмжийн

угсралтын ажил, 300 тн шахмал түлш нөөцлөх агуулахын барилгын ажил хийгдэж эхэлсэн ажлын гүйцэтгэл 70,0 хувьтай явагдаж байна.

Зураг 1.11

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг айл өрхүүдэд хэвшүүлж, дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх ажлын хүрээнд 13 суманд хоёрдогч түүхий эд хүлээн авах 28 цэг байгуулагдаж, 301,8 тн дахивар хаягдлыг цуглуулан аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг “Эко цэнэ”, “Цэмцгэр” төвүүд болон Улаанбаатар хот руу нийлүүлээд байна. Есөнзүйл, Гучин-Ус, Баян-Өндөр, Уянга, Бүрд, Арвайхээр сумд 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн 69,0 сая төгрөгийн хөрөнгөөр хоёрдогч түүхий эдийг нягтруулах пресслэгч төхөөрөмжийг худалдан авч, аймгийн хэмжээнд 12 сум, 19 пресслэх төхөөрөмжтэй болоод байна.



Дүгнэлт:

Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 191 арга хэмжээнээс үр дүнтэй болон тодорхой үр дүнд хүрч, эдийн засаг, засаглалын бодлого, “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын зорилт 90-ээс дээш хувьтай хэрэгжиж, хүний хөгжил, ногоон хөгжил, байгаль орчин бодлогын зорилт 90,0 хувь хүрээгүй байна. Үүний шалтгаан нь дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахлын улмаас жуулчдын тоо буурсан, төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдаж зарцуулахаар төлөвлөгдсөн эх үүсвэр нь өөр төсөл арга хэмжээнд зарцуулсны улмаас 3 арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон байна.

Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд эрчимжүүлэх шаардлагатай 8, үнэлэх боломжгүй 3 арга хэмжээнээс 2023 оны аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд цаг үеийн холбогдолтойгоос бусад давтагдах шинж чанартай арга хэмжээнүүд болон бүтээн байгуулалтын 11 арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Зөвлөмж:

-Аймгийн 2023 оны жилийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээг холбогдох төсвийн шууд захирагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллах;

-Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад холбогдох бодлогын хэлтсүүд хагас жилээр хяналт тавьж, удааширсан болон тасрах магадлалтай заалтуудыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шалтгаан нөхцөлийг тодорхойлж, салбар дундын уялдааг ханган эрчимжүүлэх ажлыг зохион байгуулахыг зөвлөж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

1.4. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 61 зорилт, 338 арга хэмжээг нэгтгэн дүгнэж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хэлэлцэж, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний 2020-2022 оны хэрэгжилт, үр дүнг 81,2 буюу жилийн хэрэгжилтийн дүнг 90,2 хувь “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн.

Хөтөлбөрийн эхний хоёр жилийн биелэлт, үр дүнгийн ерөнхий үнэлгээг бодлогын зорилтын бүлэг тус бүрээр арга хэмжээний тоо, түүний хэрэгжилтийн хувийг хүснэгтлэн үзүүлэв.

Хүснэгт 1.5

Д/д	Бүлэг	Зорилт	Арга хэмжээ	0 хувь	30 хувь	50 хувь	70 хувь	90 хувь	100 хувь	Арга хэмжээ	2020-2022 оны хэрэгжилт
1	Хүний хөгжил	29	146	3	4	10	36	68	25	80,5	81,2 (90,2)
2	Эдийн засаг	15	80	1	5	15	14	32	13	75,8	
3	Засаглалын бодлого	9	52	0	2	1	15	31	3	81,7	
4	Ногоон хөгжил, аялал жуулчлал	4	30	1	3	4	9	10	3	70,7	
5	Ковид 19	4	30	0	0	0	1	5	24	97,3	
	Нийт	61	338	5	14	30	75	146	68	81,2	

Дээрх хүснэгтэн мэдээллээс үнэлгээ тус бүрд хамаарах заалтын тоог нийт заалтад эзлэх хувиар тооцон гаргаж графикаар үзүүлэв. Арга хэмжээний хувьд хэрэгжилтийн жинг тооцвол:

Хүснэгт 1.6

Д/д	Хэрэгжсэн байдал	Хувь	Нийт арга хэмжээ	Эзлэх хувь
1	Үр дүнтэй	100	68	20,1
2	Тодорхой үр дүнд хүрсэн	90	146	43,2
3	Эрчимжүүлэх шаардлагатай	70	75	22,2
4	Эрчимжүүлэх шаардлагатай	50	30	8,9
5	Үр дүнгүй	30	14	4,1
6	Үр дүнгүй	0	5	1,5
	Дүн		338	100,0


Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлгээс “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого бүлгийн 2020-2022 оны хэрэгжилтийн хувь бусад салбараасаа хамгийн өндөр буюу 97,3 хувьтай дүгнэгдсэн байна. Мөн нийт 338 арга хэмжээнээс 146 арга хэмжээ (43,2%) тодорхой үр дүнд хүрсэн буюу 90-ээс дээш хувиар үнэлэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих хугацаанд аймгийн эдийн засаг, нийгмийн салбарын ахиц, өөрчлөлтөөс дурдвал:

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022 онд 156,7 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тайлант онд аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн урьдчилсан дүнгээр 670,0 тэрбум төгрөгт хүрч, ажлын байр 1280-аар нэмэгдэж, аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 62,0 тэрбум төгрөгт хүрсэн.

Зураг 1.12



Боловсролын салбарт 2022 онд улсын төсвийн 8,0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 2 шинэ сургууль, 2 сургуулийн өргөтгөлийг ашиглалтад оруулж, сургуулийн хүчин чадал 1040 суудлаар нэмэгдэн, хамран сургалт 95,0 хувьд хүрч, багш, сурагчдын ажиллаж суралцах орчин, нөхцөл сайжирсан.

Зураг 1.13



Боловсролын чанарын үзүүлэлт болох элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр 2020, 2021 онуудад улсад нэгдүгээр байр, 2022 онд 527,5 хэмжээст онооны дундажтай улсын хэмжээнд хоёрдугаар байрт үнэлэгдэв.

Зураг 1.14



Улсын төсвийн хөрөнгөөр 4 суманд 1200 хүүхдийн хүчин чадалтай сургууль, 6 суманд 650 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг, Арвайхээр сумын “Тэмүүлэл-Эрдэм”, Хархорин сумын 1 дүгээр сургууль, Хархорин сумын 2 дугаар сургуулиудад тус тус 250 суудалтай спорт заал баригдаж барилгын ажил 50 хувьтай явагдаж байна.

Хорт хавдрыг эрт үед нь оношлох, илрүүлэх зорилгоор улсын төсвийн 2,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг байгуулан эрт илрүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Зураг 1.15



2022 онд “Хөх манал” уламжлалтын эмнэлэг, нөхөн сэргээх, дотор, лаборатори чиглэлээр, “Чинмэнд” эмнэлэг уламжлалт, нөхөн сэргээх, амбулаторийн чиглэлээр, “Агьманба” уламжлалт, сэргээн засах чиглэлээр эмнэлгийн өргөтгөл барьж үйл ажиллагаагаа өргөтгөсөн. Шинээр Сидармед хувийн эмнэлэг байгуулагдаж дотор, уламжлалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 1.16



Аймгийн төвд 2022 онд 175 айлын 10 орон сууц ашиглалтад орж, 165 айлын 6 орон сууцны барилгын ажил явагдаж байна. Арвайхээр хотын шинэ суурьшлын бүсэд “Хаус хороолол” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, Инженерийн дэд бүтцийн хангамж төслийн хүрээнд Бат-Өлзий, Уянга, Хужирт сумдад инженерийн шугам сүлжээ байгуулах барилга угсралтын ажил явагдаж байна.

Мөн Хужирт суманд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр цэвэр усны шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээний барилга угсралтын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байна. Арвайхээр сумын 10, 11 дүгээр багийн гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний холболтын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй баригдаж байна.

Зураг 1.17



Арвайхээр хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Баянтээгийн нүүрсний уурхайг түшиглэн байгуулагдсан “Баянтээг

түлш” орон нутгийн өмчит ХХК нь сүүлийн хоёр жилд 842 тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж, Арвайхээр сумын 300-500 айл өрхийн хэрэглээнд нэвтрүүлэв.

Зураг 1.18



Бүгд Найрамдах Солонгос улсын хөнгөлөлттэй зээлээр Арвайхээр суманд 30 Гкал/цаг-ийн хүчин чадалтай дулааны станц, дулаан дамжуулах төвийн барилгын ажлыг эхлүүлэв.

Зураг 1.19



Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар аймагт жилд нэг сая малын арьс шир боловсруулах хүчин чадалтай томоохон үйлдвэр ашиглалтад орж, орон нутгийн 100 орчим иргэдийг ажлын байраар хангаж, 430 мянган арьс, шир боловсруулан Бүгд Найрамдах Турк улс, Бүгд Найрамдах Хятад Ард улс руу бүтээгдэхүүнээ гаргахаар яриа хэлэлцээр хийгдэж байна.



Аймгийн хэмжээнд атаршсан газрын тооллогыг хийж, 1147,6 га талбайг эргэлтэд оруулж, 5858,5 га талбайд малын тэжээл тариалан 4,7 цн ургац хураан авсан нь өмнөх онтой харьцуулахад тариалалт 2,6, ургац 2,5 дахин өссөн.

Зураг 1.20



Малын тоо толгойн албан татвараас 2,7 тэрбум төгрөгийг бэлчээр хамгаалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдын бүлгийг чадавхжуулах, малын тэжээл тариалах, малын чанар сайжруулахад зарцуулсан.

Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, чадавхжуулах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг батлан аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байна. Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын давхардсан тоогоор 759 сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 27 удаа зохион байгуулж, тусгай шалгалтад тэнцсэн 225 иргэн тухайн албан тушаалд томилогдсон.

Зураг 1.21



Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний операторын үйлчилгээ жигдэрч, 19 сумын Засаг даргын Тамгын газрын оператор ажилтнаар дамжуулан 243 төрлийн 11324 цахим үйлчилгээг иргэдэд үзүүлсэн байна.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран нутгийн захиргааны 14 байгууллагын 67 үйлчилгээг E-Mongolia системд нэвтрүүлээ.

Зураг 1.22



Орон нутгийн төсвийн 70,0 сая төгрөгөөр 15 суманд киоск машин хүлээлгэн өгөв. Энэхүү киоск машинаар дамжуулан иргэд сум орон нутагтаа төрийн байгууллагын 100 гаруй төрлийн үйлчилгээний төлбөр тооцоог хийх боломж бүрдэж байна.

Зураг 1.23



Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар сумдад үүрэн холбооны сүлжээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч 13 сумын алслагдсан багуудад Юнител, Мобикомын 4G сүлжээг шинээр нэвтрүүлсэн.

Авлигатай тэмцэх газар, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран 2022 онд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, орон нутаг дахь төрийн байгууллага, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Авлигын эсрэг миний-бидний оролцоо” сэдэвт 45 хоногийн аян зарлан, нийт 9 ажил, арга хэмжээг төлөвлөн, сум, агентлагуудад хүргүүлэн, олон нийтийг хамруулан зохион байгуулсан.

Зураг 1.24



Сүүлийн хоёр жилийн хугацаанд аймгийн хэмжээнд 430 мянга гаруй мод, бут тарьж, төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ өмнөх оны суурь түвшингээс 31 га талбайгаар, 2020 оны суурь түвшингээс 45 га-аар нэмэгдэж, 176 га-д хүрлээ. Нийт тарьсан модны 60 хувийг нийтийн эзэмшлийн талбайд, 40 хувийг аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхүүд тарьсан байна.

Шинээр мод үржүүлгийн газар байгуулах, хуучин мод үржүүлгийн газруудыг хүчин чадлыг нэмэгдүүлэхэд орон нутгаас бодлогоор дэмжиж ажилласны үр дүнд энэ онд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, иргэдийн тоо 12-оор нэмэгдэж, аймгийн хэмжээнд 22 мод үржүүлгийн газарт жилд 2 саяас доошгүй тарьц суулгац бэлтгэх боломжтой болов.

Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын бүс Бат-Өлзий сумын нутаг дахь Орхон гол, Цагаан гол, Могойтын гол, Үүртийн тохойн төмөр бетонон гүүр, Могойтын голоос Орхон голын гүүр хүртэл 7,7 километр сайжруулсан авто замыг ашиглалтад оруулж, дотоод, гадаадын жуулчид, байгалийн үзэсгэлэнт газраар аялахад төдийгүй, нутгийн малчид саадгүй зорчих боломж бүрдсэн.

Хархорин, Эрдэнэ Зуу музейг холбосон аялал жуулчлалын гудамж байгуулах ажлыг улсын төсвийн хөрөнгө 2,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар тохижуулж байна.

Аймгийн хэмжээнд 2022 онд дотоод, гадаадын 38,7 мянган жуулчид, аялагчдыг хүлээн авсан байна.

Аймгийн аялал жуулчлалын цахим хөтөч “Uvurkhangai travel” гар утасны аппликейшныг хийж, цахим үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг сайжруулж, хэрэглэгчдэд хүргэлээ.

“Өвөрхангайд үйлдвэрлэв” төвөөс гадна “Хужиртад үйлдвэрлэв”, “Хархоринд үйлдвэрлэв” төвүүд шинээр ашиглалтад орж, орон нутгийн үйлдвэрлэгчдийн 700 орчим нэр төрлийн бүтээгдэхүүнийг борлуулж байна. Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд сүүлийн 2 жилийн хугацаанд 68 аж ахуйн нэгж оролцож, нутгийн брэнд бүтээгдэхүүнээ сурталчлан, хамтран ажиллах гэрээ хэлэлцээрийг байгуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжилт удаашралтай хэрэгжиж буй зарим арга хэмжээнүүд байна. Үүнд:

1.Бат-Өлзий суманд олон улсын стандартад нийцсэн цанын бааз байгуулна. (1.3.2.4)

2.Арвайхээр хотод мэргэжлийн байгууллагуудтай хамтран төвийн бүсийн “Хөгжим бүжгийн коллеж” байгуулна. (1.4.1.1)

3.Хархорин сумыг аялал жуулчлал, түүх соёлын төв болгон хөгжүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран нисэх буудлыг олон улсын “4C” зэрэглэл бүхий агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор болгоно. (2.1.1.3)

4.“Орхон-Онги” эко төслийг салбарын яамтай хамтран хэрэгжүүлнэ.(4.1.1.6)

Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгаас дангаар шийдвэрлэх бололцоогүй, хөрөнгө санхүүжилт ихээхэн шаардах ажлууд бөгөөд жил бүр улсын төсөвт шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгуулахаар тооцоо судалгаа гарган санал хүргүүлдэг боловч одоогоор шийдвэрлэгдээгүй хэрэгжилт удаашралтай байна.

Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 15/01 дүгээр тогтоолын хавсралтаар аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нэмж тусгах арга хэмжээг боловсруулан батлуулсан.

Дүгнэлт

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн www.unelgee.gov.mn цахим санд хугацаанд нь байршуулсан.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3 дугаар хавсралтад заасан загвараар аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны байдлаар нэгтгэн дүгнэж тайлагнасан байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж, алдаа дутагдлаа засаж, сайжруулсан байна. Үүнд:

Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон журмын хавсралтад заасан загвараар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнасан.

2021 оны жилийн эцсийн байдлаар тасарсан, удааширч байгаа арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүдэд чиглэл хүргүүлж, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалаагүй арга хэмжээний хэрэгжилтийг тодорхой түвшинд ханган ажилласан байна.

Зөвлөмж

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.8.4-т заасан зарчмыг баримтлан төлөвлөлтийн дагуу үр дүнд суурилан тайлагнахад анхаарах чиглэлээр хариуцах бодлогын хэлтсүүдэд зөвлөсөн.

Бодлогын хэлтсүүд хариуцсан салбараас мэдээлэл нэгтгэхдээ мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг холбогдох агентлаг, Статистикийн хэлтэс, сумдын Засаг даргын Тамгын газраас нягтлан тодруулж, ажлын гүйцэтгэлийн чанар, үр дүнг чухалчлан, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд харьцуулан тооцож, нотлох баримтад тулгуурлан үнэлэх нь зүйтэй байна.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дүнд хийгдсэн ажлуудыг орон нутгийн иргэдэд сурталчлах чиглэлээр орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, ажлын гүйцэтгэлд анхаарах шаардлагатай байна.

Нийт заалтаас хараахан үр дүнтэй хэрэгжээгүй байгаа арга хэмжээнүүдийг салбар хариуцсан бодлогын хэлтсүүд 2023 оны нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг бодит үр дүнд хүргэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Тайлангийн нэгтгэлд салбар бүрийн тоон үзүүлэлт, харьцуулалт зэргийг шалгуур үзүүлэлт тус бүрд нийцүүлэн хувь, чанар, тоон үзүүлэлтээр маш сайн илэрхийлж, баталгаажуулан тайлагнахыг бодлогын хэлтсүүдэд зөвлөсөн.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

1.5.ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

“Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийн үнэлгээг 2022 оны хүрсэн түвшинг зорилтот түвшин болон суурь үзүүлэлттэй харьцуулан дүгнэлээ.

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг батлагдсан 45 үзүүлэлтийн дагуу гаргаж, 2022 оны гүйцэтгэлийг тооцоход 93,4 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Биелэлт гараагүй 1 үзүүлэлт байгаа нь оюутан цэрэг сургалтад хамрагдах суралцагчдын тоо байгаа ба Батлан хамгаалахын сайдаас “Оюутан цэрэг” сургалтыг төсвийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан 2022 онд аймаг, орон нутагт зохион байгуулаагүй болно. Харин Улаанбаатар хотод зохион байгуулсан “Оюутан цэрэг” сургалтад тус аймгийн харьяат 14 оюутан хамрагдсан байна.

Хүснэгт 1.7

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Өөрчлөлтийн хувь	Үнэлгээ
			2020	2022			
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ							
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	614,211.8	728,200.0	728,210.0 ¹	100,0	100,0
2	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ	сая төгрөг	5.3	5.8	6.3 ²	108,6	100,0
3	Төсвийн орлого	сая төгрөг	85,288.6	91,000.0	90,462.8 ³	99,4	99,4
4	Төсвийн зардал	сая төгрөг	84,055.6	88,115.9	87,055.3 ⁴	98,4	98,4
5	Төсвийн тэнцэл		1,233.0	2,884.1	3,407.5 ⁵	118,1	100,0
6	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	хувь	50.0	74,0	74,0	100,0	100,0
7	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь	хувь	61,2	66,0	62,2	94,2	94,2
8	Ажилгүйдлийн түвшин	хувь	6,7	6,2	6,3 ⁶	98,4	98,4
9	Ажиллах хүчний оролцооны хувь	хувь	68,4	68,9	70,9 ⁷	102,9	100,0
10	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	хувь	74,0	74,8	75,3	100,7	100,0
11	Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ын нийгмийн	хувь	50,6	52,8	53,1	100,6	100,0

	даатгалд эзлэх хувь						
12	Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо	тоо	1000	1100	1680	152,7	100,0
13	Хэрэглээний үнийн индекс	индекс	5,4	4,0	15,2	26,3	26,3
14	Малын тоо	мянган толгой	5,625.5	5,300.0	4,589.3	86,6	86,6
15	Хураан авсан үр тариа	мянган тонн	3,6	3,7	6.9	186,5	100,0
16	Хураан авсан малын тэжээл бусад	мянган тонн	2,3	4,2	7,3	173,8	100,0
17	Хураан авсан хүнсний ногоо	мянган тонн	2,6	2,7	2,7	100,0	100,0
18	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	тоо	-	29,300	38,380	131,0	100,0
19	Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо	тоо	961	1061	1123	105,8	100,0
20	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь	хувь	6,8	7,0	8,4	120,0	100,0
21	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	95,5	95,7	95,7	100,0	100,0
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ДУНДАЖ						109,7	95,4
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ							
22	Хүн амын дундаж наслалт	жил	70,8	70,99	71,9	101,3	100,0
23	Хүний хөгжлийн индекс	индекс	0,65	0,67	0,68	101,5	100,0
24	Жендерийн тэгш бус байдлын индекс	индекс	0,79	0,77	0,8	96,3	96,3
25	Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	613	601	696	115,8	84,2
26	Иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшин	хувь	23,7	23,9	45,0	188,3	100,0
27	PM2.5 тоосонцорын жилийн дундаж агууламж	М кг/м ³	Тоосонцор хэмжих багажны хэвийн бус ажиллагаанаас шалтгаалан үзүүлэлт гарах боломжгүй байгаа.				

28	PM10 тоосонцорын жилийн дундаж агууламж	М кг/м ³	105,0	90,0	90,0	100,0	100,0
29	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	хувь	4,7	4,7	4,7	100,0	100,0
30	Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	хувь	0,2	1,00	1,00	100,0	100,0
31	Хот суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	хувь	10,0	20,0	40,7	203,5	100,0
32	100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин	Промиль	38,4	18,2	50,3	36,2	36,2
33	1,000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	Промиль	14,6	12,6	14,6	86,3	86,3
34	10,000 хүн амд вируст гепатитын өвчлөл	тоо	0,7	0,68	0,8	85,0	85,0
35	Тухайн жилийн товлот дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	хувь	99,0	99,2	98,2	99,0	99,0
36	Артерын даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	92,0	92,2	81,5	88,4	88,4
37	Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	93,1	93,3	92,7	99,4	99,4
38	Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	42,8	54,8	30	54,7	54,7
39	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	88,5	90	85	94,4	94,4
40	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	100,0	100,0	92,8	92,8	92,8

41	Цэцэрлэгийн бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо	35,3	34,5	32,9	104,9	100,0
42	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо	27,4	26,5	28,8	92,0	92,0
43	Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо	тоо	518,1	524	527,5	100,7	100,0
44	Оюутан цэрэг сургалтад хамрагдах суралцагчдын тоо	тоо	Батлан хамгаалахын сайдаас “Оюутан цэрэг” сургалтыг төсвийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан 2022 онд аймаг, орон нутагт зохион байгуулаагүй болно. Харин Улаанбаатар хотод зохион байгуулсан “Оюутан цэрэг” сургалтад тус аймгийн харьяат 14 оюутан хамрагдсан.				
45	Төрийн цахим үйлчилгээний тоо	тоо	182	192	243	126,6	100,0
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ДУНДАЖ						103,0	91,3
НИЙТ ДУНДАЖ						106,4	93,4

[1] 2022 оны жинхэнэ гүйцэтгэл гараагүй тул 2022 оны урьдчилсан гүйцэтгэлийн мэдээг авав. Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Статистикийн хэлтэс

[2] 2022 оны жинхэнэ гүйцэтгэл гараагүй тул 2022 оны урьдчилсан гүйцэтгэлийн мэдээг авав. Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Статистикийн хэлтэс

[3] Үндэсний статистикийн хорооны www.1212.mn мэдээллийн сан дээр мэдээлэл эцэслэж гараагүй тул аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээллийг авав.

[4] Үндэсний статистикийн хорооны www.1212.mn мэдээллийн сан дээр мэдээлэл эцэслэж гараагүй тул аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээллийг авав.

[5] Үндэсний статистикийн хорооны www.1212.mn мэдээллийн сан дээр мэдээлэл эцэслэж гараагүй тул аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээллийг авав.

[6] Урьдчилсан байдлаар 2022 оны 4 улирлын дунджаарх мэдээллийг авав. Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа (www.1212.mn)

[7] Урьдчилсан байдлаар 2022 оны 4 улирлын дунджаарх мэдээллийг авав. Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа (www.1212.mn)

Нийт 44 үзүүлэлт 93,4 хувийн биелэлттэй дүгнэгдсэн ба нийгэм болон эдийн засгийн салбараар хуваан зорилтын биелэлтийг тус бүрд нь авч үзвэл нийгмийн салбарын 23 зорилтын биелэлтийн дундаж 91,3 хувь гарсан байна. Үүнд 10 үзүүлэлт 100,0 хувь биелсэн, 10 үзүүлэлт 83,5-99,4 хувьтай биелсэн ба 2 үзүүлэлт хангалтгүй буюу 36,2 болон 54,7 хувийн биелэлттэй гарсан байгаа нь 100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин, хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь гэсэн 2 үзүүлэлт байна. Өвөрхангай аймагт 2022 онд эхийн эндэгдэл 1 тохиолдол гарсан нь эх барихын шалтгаант эхийн эндэгдэл бөгөөд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой 3 дугаар хожимдол байсан байна. Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь 54,7 хувийн биелэлттэй байгаа нь Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Журам батлах тухай” А/139 дүгээр тушаалын дагуу 2022 оны 5 дугаар сараас эрт илрүүлгийн үйл ажиллагаа эхэлж 9 дүгээр сараас программ жигдэрсэн тул хамралт буурсан үзүүлэлттэй байна.

Эдийн засгийн салбарын 21 зорилтын биелэлтийн дундаж 95,4 хувь гарсан байна. Үүнд 15 үзүүлэлт 100,0 хувь, 5 үзүүлэлт 83,5-99,4 хувьтай үнэлэгдлээ. Биелэлт хангагдаагүй 1 үзүүлэлт байгаа нь хэрэглээний үнийн өсөлт байна. Зорилтын биелэлт бага хувьтай үнэлэгдсэн байдалд дүн шинжилгээ хийхэд хэрэглээний үнийн индекс 3,7 дахин өссөн нь

ковид-19 цар тахлын нөлөөллөөс үүдэлтэй, эдийн засгийн өсөлт саарсан, мөн дэлхийн нийтийг хамарсан тээврийн салбарын хямралаас үүдэлтэй барааны үнийн өсөлтөөс шууд хамааралтай үзүүлэлт гэж дүгнэлээ.


Өвөрхангай аймаг хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг хангаж ажиллахын тулд малын тоог нэмэгдүүлэхээр төлөвлөж ажилласан хэдий ч байгаль, цаг агаарын давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн сүүлийн жилүүдэд малыг чанаржуулах, тооноос чанарт шилжих, бэлчээрийн даацыг бууруулах бодлого барьж ажиллаж эхэлсэн, мөн 2021 оноос хэрэгжиж эхэлсэн малын хөлийн татварын бодлого нь малын тоо буурах шалтгаан болсон гэж дүгнэв.

Аймгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшинг илэрхийлсэн зарим үзүүлэлтүүдийг сүүлийн жилүүдээр харвал:

-Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн суурь түвшнээс 18,6 хувиар, зорилтот түвшнээс 0,001 хувиар тус тус өссөн үзүүлэлт гарсан нь эдийн засгийн салбарын гол зорилт биелсэн үр дүнд хүрснийг илтгэж байна.

Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн, тэрбум төгрөгөөр 2018-2022 онд


График 1.5



-Ажилгүйдлийн түвшин суурь түвшин буюу 2020 онд 6,7 хувь байсан ба 2022 онд 6,2 хувьд хүргэх зорилт тавьсан нь тухайн оны 4 дүгээр улирлын урьдчилсан тооцоогоор 6,4 хувьд хүрч зорилтот түвшин 98,4 хувьтай биелсэн байна.

Ажилгүйдлийн түвшин, улс болон аймагт, 2018-2022 онд

График 1.6




Тайлбар:*-2022 оны 4 дүгээр улирлын байдлаар урьдчилсан тооцоолол ба 2021 оны жилийн эцсийн тооцоолол гараагүй болно. Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, (www.1212.mn)

-Аймгийн хэмжээнд хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо малын тэжээлийн хэмжээ зорилтот түвшнээс бүгд өссөн үзүүлэлттэй гарсан байна. Тухайлбал үр тариа хураан авалт суурь түвшин болон зорилтот түвшнээс 1,9 дахин, малын тэжээл хураан авалт суурь түвшнээс 3,2 дахин, зорилтот түвшнээс 1,7 дахин тус тус өссөн байна.

Нийт хураан авсан ургац, төрлөөр, тн-оор, 2018-2022 онд

График 1.7



Зорилтот түвшинг 100,0 хувь хангасан 25 үзүүлэлтийн 36,0 хувь буюу 8 үзүүлэлт нь зорилтот түвшнээс 15,0-аас дээш хувиар давсан буюу маш сайн биелсэн үнэлгээтэй байна. Энэ нь эдийн засгийн салбарын 5 үзүүлэлт, нийгмийн салбарын 3 үзүүлэлт байна. Тодруулбал төсвийн тэнцэл, шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо, хураан авсан үр тариа, хураан авсан малын тэжээл, хүлээн авсан гадаад, дотоод жуулчдын тоо, инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь зэрэг үзүүлэлтүүд байна.

Орон нутгийн боловсролын чанарыг илэрхийлэх элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр 2016 онд 527,1 хэмжээст оноо (улсад 1), 2017 онд 520,7 оноо (улсад 2), 2018 онд 520,4 оноо (улсад 3), 2019 онд 518,1 оноо (улсад 4), 2020 онд 530,4, 2021 онд 538,6 хэмжээст оноотой улсад 1 дүгээр байр эзэлж байсан бол 2022 онд 527,5 хэмжээст оноотойгоор улсад хоёрдугаар байр эзэлсэн амжилт үзүүлжээ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ**2.1.МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг гэрээнд тусгагдсан арга хэмжээний зорилт, хүрэх түвшинг шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэллээ.

Тайлант онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, төсвийн ерөнхийлөн захирагч 19 сайдаас (Монгол улсын Ерөнхий сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан батламж болон Засгийн газрын гишүүдтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийн хамт) аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажилласан бөгөөд гэрээ (батламж)-ний хэрэгжилтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад гэрээнд заасан хугацаанд бүрэн тайлагнаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд 2023 оны 02 дугаар сарын 19-ний өдөр буюу тайлант хугацаанд байршуулж, гэрээний хэрэгжилтийн дундаж 94,4 хувьтай дүгнэгдлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Хүснэгт 2.1

№	Засгийн газрын гишүүн	Арга хэмжээний тоо	Биелэлт хувиар						Үнэлгээ
			100	90	70	50	30	0	
1.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	25	14	9	2				94,0
2.	Шадар сайд	41	30	5	5		1		93,4
3.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	48	38		7	2	1		92,0
4.	Сангийн сайд	67	58	4	3	1	1		96,2
5.	Хууль зүй, дотоод хэргийн сайд	31	19	1	9	1	1		87,0
6.	Барилга, хот байгуулалтын сайд	103	71	7	17	4	1	3	88,8
7.	Батлан хамгаалахын сайд	35	22	11	1	1			94,5
8.	Боловсрол, шинжлэх ухааны сайд	69	44	24	1				96,0
9.	Зам, тээврийн хөгжлийн сайд	32	24		6			2	88,1
10.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	35	25	1	6	1		2	87,4
11.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	53	42	5	5			1	94,3

12.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	67	39	20	8				93,4
13.	Эрчим хүчний сайд	14	12		2				95,7
14.	Эрүүл мэндийн сайд	74	58	7	9				95,4
15.	Эдийн засаг, хөгжлийн сайд	9	6	2				1	86,6
16.	Соёлын сайд	48	32	10	4	2			93,3
17.	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	22	13	7		2			92,2
18.	Гадаад харилцааны сайд	10	4	5		1			90,0
19.	Ерөнхий сайдтай байгуулсан батламж	9	8	1					98,8
НИЙТ		792	559	119	85	15	5	9	94,4

Гэрээний хэрэгжилтэд хийсэн чанарын үнэлгээ:

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 19 гэрээний нийт 792 арга хэмжээнээс 100 хувийн хэрэгжилттэй 559 буюу 70,5 хувь, 90 хувийн хэрэгжилттэй 119 буюу 15 хувь, 70 хувийн хэрэгжилттэй 85 буюу 10,7 хувь, 50 хувийн хэрэгжилттэй 15 буюу 1,8 хувь, 30 хувийн хэрэгжилттэй 5 буюу 0,6 хувь, 9 арга хэмжээ 0 хувьтай буюу 1,1 хувийг тус тус эзэлж байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2.5-д заасан дагуу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулагдаагүй буюу хэрэгжилт 0 хувьтай байгаа 9 арга хэмжээний хэрэгжээгүй шалтгаан, нөхцөлийн заримаас дурдвал:

1.Барилга, хот байгуулалтын сайдын гэрээний 15 дугаар заалтад тусгагдсан “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулах.” арга хэмжээний хувьд аймгийн Газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын зардлыг орон нутгийн төсөв (нийт төсөвт өртөг 750,0 сая.төг)-т суулгаж, тендер шалгаруулалт зарлагдсан боловч зөвшөөрөгдсөн санхүүжилт татагдсан тул ажил зогссон.

2.Зам, тээврийн хөгжлийн сайдын гэрээний 1.31 дэх заалтад тусгагдсан “Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын хөлөг хөөрч, буух түр зурваст хариуцагч томилон, байнгын арчлалт, хамгаалалт хийхэд гаргах зардлыг аймгийн төсөвт суулгах талаар арга хэмжээ авч ажиллах” арга хэмжээ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 18.1.4 дэх хэсэгт зааснаар хэрэгжүүлэх боломжгүй болсон, мөн гэрээний 1.32-т заасан “Иргэний нисэхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн “Аэродромын төлөвлөлт ба ашиглалт” техникийн баримт бичиг батлах тухай А/131 дүгээр тушаалын 7.5.4-д заасан “Аэродром орчмын аюулгүйн бүсийн ангилал ба ашиглалт”-ын шаардлагуудыг хэрэгжүүлэн аюулгүйн бүсийг шинэчлэн тогтоож хамтран ажиллах” арга хэмжээний хувьд аймгийн хэмжээнд Аэродром орчмын аюулгүйн бүсийн ангилал тогтоох нь Арвайхээр хотын шинэ төвийн хэсэгчилсэн төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор зөрчилдөж байгаа бөгөөд Аэродромын хамгаалалтын бүсэд иргэнд өмчлүүлсэн 762, иргэнд эзэмшүүлсэн 408, аж ахуйн нэгжид эзэмшүүлсэн 132 нэгж талбар байна. 2009 оноос Арвайхээр хот байгуулалтын ерөнхий

төлөвлөгөө, Арвайхээр хотын шинэ төвийн хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу төрийн болон аж ахуйн нэгж байгууллага, иргэнд газар эзэмшүүлж эхэлсэн ба цаашид аэродромыг нүүлгэх шаардлагатай байгааг тайланд тусгасан байна.

3.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын гэрээний 6.2-т тусгагдсан “Малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалтад 2 мэргэжилтэнг хамруулан мэргэжлийн чадамж олгох” заалт нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотойгоор сургалтад хамруулах зардлыг орон нутгаас зохицуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

4.Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын гэрээний 3.2.2.л заалтад тусгагдсан “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн Дэд зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, холбогдох зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгаж ажиллах” арга хэмжээний хүрээнд орон нутгийн төсөвт тухайн чиглэлээр хөрөнгө төлөвлөөгүй учир хэрэгжээгүй байна.

Дээрх нөхцөл, шалтгаанаас үзэхэд 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж байгаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор мөн тухайн арга хэмжээг нэг жилийн хугацаанд шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдлаас шалтгаалан хэрэгжээгүй, хэрэгжүүлэх чиглэлээр ямар нэгэн ажил зохион байгуулах нөхцөл бүрдээгүй байна.

2022 онд эрх шилжиж ирсэн ажлын санхүүжилтийн дүнг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2.2

№	Засгийн газрын гишүүн	Санхүүжилтийн дүн /сая/	Гүйцэтгэлийн хувь
1.	Биеийн тамир, спортын улсын хорооны дарга	500,0	100
2.	Монгол Улсын шадар сайд	2,990.0	100
3.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	350,0	100
4.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	3,250.0	100
5.	Барилга, хот байгуулалтын сайд	4,550.0	75
6.	Боловсрол, шинжлэх ухааны сайд	24,023.4	100
7.	Соёлын сайд	3,100.0	100
8.	Зам, тээврийн хөгжлийн сайд	1,500.0	100
9.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	400,0	100
10.	Эрчим хүчний сайд	200,0	100
11.	Эрүүл мэндийн сайд	18,300.0	100
НИЙТ ДҮН		59,163.4	97,7

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгээс зарим онцлог үйл ажиллагааг тоймлон авч үзвэл:

1.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын тоног төхөөрөмжийн шинэчлэлийг 143,8 сая төгрөгөөр хийж, Сант сумын Засаг даргын Тамгын газрын барилгыг 177,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засварлав.

Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний операторын үйлчилгээ жигдэрч, тайлант хугацаанд 19 сумын Засаг даргын Тамгын газрын оператор ажилтнаар дамжуулан 243 төрлийн 11324 цахим үйлчилгээг үзүүлэн, нутгийн захиргааны 15 байгууллагын 67 үйлчилгээг E-Mongolia системд нэвтрүүлж ажилласан байна.

Хотоос хөдөө рүү шилжин суурьшиж байгаа иргэн, өрх, хөдөлмөр эрхлэгч, аж ахуйн нэгжийг бүх талаар дэмжих зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлэх, орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжийг бүрдүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх” хөтөлбөрөөс аймгийн хэмжээнд нийт 44,5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1407 иргэн, аж ахуйн нэгжид олгосон бол хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээлд 1365 малчин өрхөд 10,5 тэрбум төгрөг, газар тариалан эрхлэгч 6 иргэн, аж ахуйн нэгжид 175,0 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.

Сум хөгжүүлэх сангаас 15 суманд нийт 223 иргэн, аж ахуйн нэгжид 1,6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, зээлийн батлан даалтын сангаас 5 аж ахуйн нэгжид 1,2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж, 562,3 сая төгрөгийн батлан даалтад хамруулсан байна. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Баруунбаян-Улаан, Хужирт сумдын зоорь барих 2 аж ахуйн нэгжид 45,0 сая, Арвайхээр, Богд сумдын өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах 2 аж ахуйн нэгжид 90,0 сая, нийт 135,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.

2.Байгаль орчин, аялал жуучлалын сайд

Аймгийн хэмжээнд “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөн, бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрүүдийн хүрээнд нийт 320,0 мянган ширхэг мод, бут тарьж, нийт тарьсан модны 36,0 мянган ширхэгийг айл өрх, 70,0 мянга орчим ширхэгийг албан байгууллага, аж ахуйн нэгжүүд, 140,0 мянган ширхэгийг төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид, 74,0 мянган ширхэгийг ойжуулалт, хамгаалалтын ойн зурваст тарьж мод бут тарих ажилд нийт 492 аж ахуйн нэгж, байгууллага, 16428 иргэн оролцож, тарьсан модны амьдралтын хувь дунджаар 80,0 хувьтай ургасан байна.

Мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор хангай, тал хээр, говиор бүсчилэн “Арвайхээр цэцэрлэгжилт” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, “Сум дундын Ойн анги”, “Өгөөмөр шунхлай” ХХК, “Бат-цэцэрлэгжилт” ХХК, “Өв-эхлэл өнгө” ХХК, “Их говийн төгөл” ХХК зэрэг 6 аж ахуйн нэгж, байгууллагад 216,0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс олгов. Тус аймагт 2021 онд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн мод үржүүлгийн 10 газарт 15 нэр төрлийн нийт 327,9 мянган тарьц, суулгац ургуулж байсан бол 2022 онд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх 11 аж ахуйн нэгж, иргэн нэмэгдэж, мод үржүүлгийн 21 газарт 18 нэр төрлийн 2,0 сая орчим тарьц суулгац ургуулсан үзүүлэлттэй байна.

3.Сангийн сайд

2022 онд улсын төсвийн орлого 5,5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 5,5 тэрбум төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 100,4 хувь, аймгийн төсвийн орлого 4,0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 4,1 тэрбум төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 101,3 хувь, орон нутгийн төсөв 16,3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 21,8 тэрбум төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 133,4 хувь нийт төлөвлөгөөний биелэлт 25,8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 31,4 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 121,7 хувиар биелүүлсэн.

Тээврийн хэрэгсэл эзэмшигчийн давхардсан тоогоор 21786 татвар төлөгчийн татвар төлөлтөд хяналт тавин автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварт 652,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 782,7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн төлөвлөгөөг 119,9 хувь, автын агаарын бохирдлын төлбөрт 50,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 53,7 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 105,7 хувь, зам ашигласны төлбөрт 293,7 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн.

4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт, үйлдвэрлэл үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд нийт 1680 шинэ ажлын байр бий болов. Үүнээс байнгын ажлын байр 749, түр ажлын байр 877, улирлын чанартай ажлын байр 54 байна. Шинээр бий болсон ажлын байрыг хөрөнгийн эх үүсвэрээр ангилан үзвэл улсын төсвийн хөрөнгө оруулалттай 1022, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай 51, хувийн хэвшлийн 607 ажлын байр бий болсон байна.

Шинээр бий болсон ажлын байрны тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28,7 хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 28,6 тэрбум төгрөг байсан бол гүйцэтгэлээр 30,6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 107,0 хувьтай хэрэгжсэн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас аймгийн 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт зөвлөмжид Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, анхаарах асуудлыг зөвлөмж болгон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2022 оны ХЭГ/1645 дугаар албан бичгээр ирүүлсэн. Зөвлөмжийн хүрээнд гэрээний төлөвлөлт, тайлагналтыг хугацаанд нь хийж, тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулсан, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр санаачилга гарган эргэх холбоотой ажилласан зэрэг ололттой талуудыг дурдаж болохоор байна.

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарах арга хэмжээг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

Салбар хариуцсан нутгийн захиргааны байгууллагуудын хувьд:

-Хэрэгжилт хангалтгүй байгаа болон хэрэгжээгүй зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр салбарынхаа бодлого төлөвлөлт, тухайн жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжих нөхцөл боломжийг эрэлхийлэх, санаачилга гаргаж ажиллах,

-Хэрэгжих боломжтой, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хялдаатай төлөвлөлт хийхэд анхаарах,

-Салбарын хэмжээнд тулгамдаж буй асуудлыг сайтар тодорхойлох, түүнийг шийдвэрлэх чиглэлээр санаачилга гаргаж, төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран ажиллах гэрээнд тусгах, талуудын хүлээх үүргийг тодорхой оруулах чиглэлээр санал санаачилга гаргах,

-Шинээр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм журмыг олон нийтэд таниулах, сурталчлах, холбогдох шат шатны албан хаагчдыг арга зүйгээр хангах,

-Цахимаар үзүүлж буй үйлчилгээний нэр төрөл, хүрээмжийг нэмэгдүүлэх зэрэгт анхаарах шаардлагатай байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

2.2.БАЙГУУЛЛАГЫН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТХяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн:

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу хэрэгжилтийн үнэлгээг тооцох аргачлалыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд хэрэгжилт 97,4 хувьтай дүгнэгдэв.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө үндсэн 3 хэсгээс бүрдэж, 27 зорилт, 55 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнасан. Үүнд :

- 1.Бодлогын баримт бичигт тусгагдсан 18 зорилт, 34 арга хэмжээний хэрэгжилт
- 2.Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 8 зорилт, 18 арга хэмжээний хэрэгжилт
- 3.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 1 зорилт, 3 арга хэмжээний хэрэгжилтийг тус тус тайлагнасан байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 55 арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг тус бүрийн гүйцэтгэлээр нь харьцуулан авч үзвэл:

Хүснэгт 2.3

Д/д	Бодлогын чиглэл	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний биелэлт (хувиар)				
				100,0	90,0	70,0	50,0	Дундаж хувь
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт								
1	Хүний хөгжил	4	10	7	-	3	-	91,0
2	Эдийн засаг	3	4	2	1	1	-	90,0
3	Засаглал	11	20	20	-	-	-	100,0
Дэд зорилтын дундаж хувь								93,6
Хоёр. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт								
4	Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт	8	18	17	-	1	-	98,3
Гурав. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт								
5	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт	1	3	3	-	-	-	100,0

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичигт тусгагдсан 34 арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг салбараар нь авч үзвэл :

Хүснэгт 2.4

Д/д	Дэд хэсэг	Нийгмийн салбараар	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн хувь			Дундаж хувь
				100,0	90,0	70,0	

1	Хүний хөгжил	Үндэсний бахархал, өв соёл	3	2		1	90,0
2		Эрүүл мэнд	1			1	70,0
3		Боловсрол	4	3		1	92,5
4		Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	2	2			100,0
5	Эдийн засаг	Санхүү, төсөв	2	2			100,0
6		Уур уурхай, хүнд үйлдвэр	1			1	70,0
7		Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа үйлчилгээ	1		1		90,0
8	Засаглал	Ёс зүй, төрийн албаны чадавх	6	5		1	95,0
9		Батлан хамгаалах	5	5			100,0
10		Хяналт-шинжилгээ, үнэлгээ	1	1			100,0
11		Хууль, эрх зүй	8	7	1		98,7

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх хэсгийг салбараар нь авч үзвэл :

Хүснэгт 2.5

д/д	Салбар	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн хувь			Дундаж хувь
				100,0	90,0	70,0	
1	Нийгмийн салбар	1	2	2	-	-	100,0
2	Санхүү төсөв	1	3	3	-	-	100,0
3	Хөрөнгө оруулалт	1	1	1	-	-	100,0
4	Төрийн захиргаа	2	6	5		1	95,0
5	Хяналт-шинжилгээ, үнэлгээ	2	4	4	-	-	100,0
6	Хууль, эрх зүй	1	2	2	-	-	100,0

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлтөд хийсэн дүн шинжилгээ:

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 55 арга хэмжээг задалж дүгнэвэл :

График 2.1



Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 55 арга хэмжээний 40 арга хэмжээ буюу 72,8 хувь нь иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх, байгууллагын албан хаагчийг сургах, чадавхжуулах болон нийгэм, олон нийтэд чиглэсэн төлөвлөлтийг хийсэн бөгөөд үлдсэн 15 арга хэмжээ буюу 27,2 хувь нь байгууллагын үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, албан хаагчийн нийгмийн

баталгааг хангах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зэрэг төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн төлөвлөлтийг хийж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Дүгнэлт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн ХЭГ/1645 дугаар албан бичгээр ирүүлсэн аймгийн 2021 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжөөр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээний гүйцэтгэл нь хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхой тайлбарлах, цаашид үргэлжлүүлэх шаардлагатай арга хэмжээг дараа жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой тусгах, шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлох, хүрэх түвшинг тухайн жилдээ биелэгдэх боломжтойгоор тодорхойлох, шалгуур үзүүлэлт хүрэх түвшин хоёрыг уялдуулах, хэмжээний хувьд хэт нүсэр байх шаардлагагүйг зөвлөмж болгосон бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийг төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналтын үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2021 онд нийт 50 зорилт 114 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг тайлагнаж байсан бол 2022 онд нийт 27 зорилт, 55 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн нь илүү оновчтой, бодлогын чанартай асуудлыг тусгахыг зорьсон, салбарын стратеги төлөвлөгөөнд үндэслэсэн, бодитой, тодорхой байхад чиглэсэн давуу талтай байна.

Зөвлөмж

-Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа арга хэмжээ бүрийн төсвийн төлөвлөлтийг сайтар хийдэг байх, хэрэгжилтийг тайлагнахдаа зарцуулалтыг бүрэн тусгаж тайлагнах;

-Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тавигдах нийтлэг шаардлагуудыг баримтлан, байгууллага, албан хаагчдыг чадавхжуулахад анхаарах шаардлагатай;

-Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа аймгийн бодлогын баримт бичгүүд болон бусад төлөвлөлтөд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй давхардуулалгүйгээр, оновчтой, бодлогын хэлтсийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэхүйц арга хэмжээг төлөвлөн, үйл явцыг бус үр дүнг чухалчлах, график, хүснэгт ашиглан тухайн арга хэмжээний хувьд өссөн, буурсан үзүүлэлтийг харьцуулалт хийж тайлагнах нь зүйтэй.


АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС


2.3.ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Төрийн албан хаагчийн сургалт, хөгжлийн чиглэлээр:

Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, чадавхжуулах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны А/561 дүгээр захирамжаар “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг баталж, төрийн албан хаагчийн сургалт хөгжлийг дэмжих, мэдлэг, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр аймгийн хөтөлбөрийн хүрээнд байгууллага бүр сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022 онд Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан тусгай шаардлага болон ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээгээр зохих шалгуурыг хангасан 3 төрийн жинхэнэ албан хаагч эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад, 14 албан хаагч ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 15 төрийн жинхэнэ албан хаагч, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 15 албан хаагч, чиглүүлэх богино хугацааны сургалтад 14 албан хаагчийг тус тус хамруулсан.





Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй “Пүрэв” гараг бүрийн 7:4:10 цахим вэбинар сургалт

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан цахим вэбинар сургалтад салбар зөвлөлийн гишүүд, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын удирдах, гүйцэтгэх албан хаагчдыг хамруулж, сургалтын ирцийн мэдээллийг хагас, бүтэн жилээр гаргуулан авч, сургалтын бичлэгийг Төрийн албаны зөвлөлийн цахим сайтаас нөхөж үзэх боломж бий гэдгийг байгууллагуудад зөвлөж ажилласан.



Төрийн албаны тухай хууль, холбогдох дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголттой болох зорилгоор төрийн байгууллагын хууль, эрх зүй, хүний нөөцийн болон дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүдтэй 14 хоног тутам уулзалт, сургалтыг танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулж хэвшлээ.

Зураг 2.1



Боловсрол, шинжлэх ухааны яам, Төрийн албаны зөвлөлтэй хамтран “Төрийн албаны үнэт зүйл ба багшийн ёс зүй, жөндөрийн мэдрэмжтэйгээр боловсрол олгох нь сургалт”-ыг танхимын болон цахим хосолсон хэлбэрээр явуулж, танхимаар 60 гаруй багш, ажилтан, цахимаар сумдын 25 сургууль, 35 цэцэрлэгийн 227 багш нар хамрагдсан.

Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, манлайллын чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академиас зохион байгуулсан 83 удаагийн сургалтад 1483 төрийн албан хаагчийг хамруулсан.


Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төрийн албаны стандартын хэрэгжилтийг хангуулах, төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөлт, төрийн албан хаагчийн тоо бүртгэл, хүний нөөцийн системд төрийн албан хаагчийн мэдээллийг үнэн зөв хөтлөх, төрийн албаны цалингийн нэгдсэн системийн хөтлөлтийг сайжруулах чиглэлээр арга хэмжээг тусган хэрэгжүүлэхийг үүрэг болгож ажилласан.

Сумын Засаг дарга, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системийн шинэчлэлт, хөгжүүлэлт, удирдлагын хүлээх хариуцлагын хүрээнд сургалт зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/561 дүгээр захирамжаар батлагдсан “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”, төрийн байгууллагуудын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд бакалаврын зэрэг олгох сургалтад 40 төрийн албан хаагч, магистрын зэрэг олгох сургалтад 65, докторын зэрэг олгох сургалтад 6 албан хаагч тус тус суралцаж байна. Бакалаврыг зэрэг олгох сургалтыг 5, магистрын зэрэг олгох сургалтыг 21 албан хаагч төгссөн. Төрийн албан хаагчдын суралцах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх санал санаачилгыг дэмжиж төрийн албан хаагчдад цалинтай чөлөө олгох, сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/561 дүгээр захирамжаар батлагдсан “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”, аймгийн сургалтын нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд 2022 оны байдлаар 439 удаагийн танхимын сургалтад 15453 төрийн албан хаагчийг, 505 удаагийн цахим хэлбэрээр зохион байгуулсан сургалтад 5505 төрийн албан хаагч тус тус хамрагдаж, давхардсан тоогоор нийт 20958 төрийн албан хаагчийг хамруулан сургалтын зардалд 122,3 сая төгрөг зарцуулсан байна.


График 2.1



Төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгуулахаар нийт 165 төрийн захиргааны албан хаагчийн материал ирүүлснийг

хянаж, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.5, 2.6-д заасан шаардлагын дагуу 158 төрийн захиргааны албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгож аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэв. Мөн харьяалах дээд шатны яам, агентлагаас 28 төрийн албан хаагчид зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон.

График 2.2



Төрийн жинхэнэ албан тушаалд хуулийн хүрээнд томилогдон ажиллаж байгаа төрийн захиргааны 74 албан хаагчийг журмын дагуу тангараг өргүүлэх ёслолын үйл ажиллагааг Өвөрхангай аймаг байгуулагдсан түүхэн өдөр, Монгол бахархлын өдөр, Бүгд Найрамдах Улс тунхагласны баярын өдрийг тус тус тохиолдуулан жилд 2 удаа зохион байгуулав.

Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын 13 (давхардсан тоогоор) сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 5 удаа зохион байгуулж 8 сул орон тоог нөхсөн. Үүнээс төрийн жинхэнэ албан тушаалд ажиллаж байгаа 4 албан хаагч тусгай шалгалт өгч тэнцэн чадахуйн зарчмын дагуу шатлан дэвшиж томилогдсон байна.

Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын 368 (давхардсан тоогоор) сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 9 удаа зохион байгуулан хамгийн өндөр оноо авсан 88 иргэнийг томилуулахаар нэр дэвшүүлснээс 85 иргэн томилогдсон байна. Үүнээс төрийн жинхэнэ албан тушаалд ажиллаж байгаа 13 албан хаагч тусгай шалгалт өгч тэнцэн чадахуйн зарчмын дагуу шатлан дэвшиж томилогдсон.

Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 18 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг 4 удаа зохион байгуулан 7 сул орон тоонд нэр дэвшүүлэн томилуулсан.

Төрийн албаны тухай хуулийн 44.1 дэх хэсэгт заасны дагуу албан тушаалын тодорхойлолтод тавигдах тусгай шаардлагыг хангасан төрийн захиргааны 34 албан хаагчийг төрийн байгууллага болон байгууллагын дотоод нэгж хооронд шилжүүлэн ажиллуулж, мөн хуулийн 44.2 дахь хэсэгт заасны дагуу төрийн захиргааны 2 албан хаагчийг сэлгэн ажиллуулсан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 55 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, сургалт, хөгжил, нийгмийн баталгааг дэмжих” хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлснээр 2019-2022 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хөтөлбөрийн үр дүнг 94,0 хувийн хэрэгжилттэй гэж

үнэлсэн. Хөтөлбөрийн үр дүнд 10000 хүн амд ногдох их эмч 2,4 хувиар, сувилагч 7,3 хувиар, эмч сувилагчийн харьцаа 1:1,4 болж өссөн. Нарийн мэргэшил эзэмшсэн их эмчийн хангалт 16,2 хувиар өссөн үзүүлэлтээр улсад тэргүүлж байна. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн тогтвортой байдал, нийгмийн асуудлыг шийдвэрлэх үүднээс 2022-2025 онд хэрэгжүүлэх "Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр"-ийг шинэчлэн боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 13/03 дугаар тогтоолоор батлуулсан.

Ерөнхий боловсролын 31 сургуулийн 1247 багшийн сургалт үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээг суралцагчийн сурах үйл ажиллагааны үр дүнгийн ахиц, суралцагчийн хөгжил хамгаалал төлөвшил, багшийн мэргэжлийн хөгжил, сургууль ба олон нийтийн үйл ажиллагаанд оруулсан хувь нэмэр гэсэн 4 багц 13 шалгуур үзүүлэлтээр үнэлэв. Үнэлгээний дүнгээр 1 дүгээр түвшинд 37 багш буюу 2,97 хувь, 2 дугаар түвшинд 121 багш буюу 9,7 хувь, 3 дугаар түвшинд 138 багш буюу 11,07 хувь, 4 дүгээр түвшинд 205 багш буюу 16,44 хувь, 4-5 дугаар түвшинд 746 багш буюу 59,8 хувьтай тус тус үнэлэгдэж, 501 багшид буюу 40,2 хувьд багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан үр дүнгийн 10-25 хувийн урамшуулал 419,7 сая төгрөг олгоод байна. Үнэлгээгээр 4 болон 5 дугаар түвшинд үнэлэгдсэн багш нарыг чадавхжуулах, дараагийн үнэлгээг ахиулахад нь дэмжлэг үзүүлэхээр Боловсролын ерөнхий газраас Модул сургалтын хөтөлбөр боловсруулагдан гарсан бөгөөд тус хөтөлбөрийн заавал болон сонгох агуулгаас сонгон судалж, мэргэжил арга зүйн чадамжаа нэмэгдүүлэх боломжтой болоод байна.

Төрийн албанд тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж үйл ажиллагаа, ажлын дадлага туршлагаараа манлайлж ажилласан 51 албан хаагчийг төрийн дээд шагнал Хөдөлмөрийн хүндэт медалиар, 31 албан хаагчийг Алтан гадас одонгоор, 4 албан хаагчийг Хөдөлмөрийн гавьяаны одонгоор, 4 албан хаагчийг Гавьяат цолоор тус тус шагнасан байна. Мөн салбарын болон аймаг, орон нутгийн бодлого шийдвэрийг үр дүнтэй хэрэгжүүлж, ажлын дадлага, туршлага, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээрээ манлайлсан 128 төрийн албан хаагчийг салбарын тэргүүний ажилтан тэмдгээр, 269 төрийн албан хаагчийг салбарын жуух бичгээр, 612 төрийн албан хаагчийг аймаг, орон нутгийн шагналаар тус тус шагнасан байна.

Нийгмийн баталгааны талаар:

Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөн тусгай шалгалтыг тухай бүр зарлан, тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан иргэнийг нээлттэй сонгон шалгаруулалтад оруулах, мөн ажлын гүйцэтгэл үр дүн, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварт тулгуурлан төрийн албан хаагчийг шатлан дэвшүүлэх арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан улс төрөөс хараат бус, чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд нийцүүлэн төрийн албаны хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын тусгай шалгалтад төрийн жинхэнэ албан тушаалд ажиллаж байгаа 4 албан хаагч, төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтад төрийн жинхэнэ албан тушаалд ажиллаж байгаа 13 албан хаагч тус тус тусгай шалгалт өгч тэнцэн чадахуйн зарчмын дагуу шатлан дэвшиж томилогдсон.

Засгийн газрын шийдвэрээр Соёлын хэлтсийг шинээр байгуулсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Соёл, урлагийн газрын албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл ирүүлсэн тул байгууллагын даргын шийдвэрээр албажуулан баталгаажуулан тусгай шалгалтын захиалгаа ирүүлсний дагуу сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгууллаа.

Төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийг хууль бусаар томилсон, халсан, чөлөөлсөн хууль бус шийдвэр гаргахгүй

байх, төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажиллах орчин нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах талаар төсвийн ерөнхийлөн болон төсвийн шууд захирагчтай аймгийн Засаг даргаас байгуулсан хамтран ажиллах гэрээ болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, төрийн байгууллагын удирдлага, хүний нөөцийн мэргэжилтнүүдэд үүрэг чиглэл өгч ажиллаж байна.

Төрийн байгууллагуудын хүний нөөцийн мэргэжилтнүүдийг боловсон хүчний томилгоо, чөлөөлөлт, хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нэмэгдэл, нийгмийн баталгааг хангах, сургалт хөгжил, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, төрийн албанд ажилласан жил, ээлжийн амралт, тэтгэмж, нөхөх төлбөр олгох чиглэлээр сургалтад хамруулан, зөвлөгөө дэмжлэг үзүүлж байна.

Хүний нөөцийн мэргэжилтнүүдтэй 14 хоног тутам цахим уулзалт, сургалтыг зохион байгуулж, хууль тогтоомжийн хүрээнд тулгамдсан, ойлгомжгүй асуудлаар хэлэлцэн нэгдсэн ойлголттой ажиллаж байна.

Сумын Засаг дарга, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтын талаар, хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системийн шинэчлэлт, хөгжүүлэлт, удирдлагын хүлээх хариуцлагын хүрээнд сургалт зохион байгуулав.

Сумын Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн мэргэжилтнүүдэд Төрийн албаны турхай хууль тогтоомжийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудал, төрийн албаны нөөц, нөөцийн бүртгэл хөтлөлт, Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хүрээнд сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүллээ.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргаас төсвийн ерөнхийлөн болон төсвийн шууд захирагч нартай байгуулсан хамтран ажиллах гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, төрийн албан хаагчдын мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх, чадавхыг бэхжүүлэх зэрэг зорилт, арга хэмжээг тусгаж, төрийн байгууллага бүр төрийн албан хаагчийн сургалт хөгжил, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу 2307 төрийн албан хаагчид 598,9 сая төгрөгийн нөхөн төлбөр, 60 дугаар зүйлд заасны дагуу 97 төрийн албан хаагчид 1,9 тэрбум төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, 61 дүгээр зүйлд заасны дагуу 1594 төрийн албан хаагчид 954,3 сая төгрөгийн дэмжлэг тусламжаа, урамшууллыг үзүүлэн нийгмийн баталгааг ханган ажиллажээ.

Хархорин суманд 11,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 100 ортой эмнэлгийн барилга, 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Төгрөг сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга, 1,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сант сумын Эрүүл мэндийн төвийн барилга тус тус баригдаж байна. Сант, Тарагт сумдын Эрүүл мэндийн төвийн эмчийн байрыг засварлаж, ашиглалтад хүлээн авч хөдөө орон нутагт мэргэжлийн боловсон хүчнээр хангах, амьдрах орчин нөхцөлийг сайжрууллаа.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар боловсролын салбарын их засварт нийт 350,0 сая төгрөг зарцуулагдаж, Баян-Өндөр, Гучин-Ус, Уянга, Зүүнбаян-Улаан, Төгрөг сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрын дээврийн их засвар, Бат-Өлзий сумын ерөнхий боловсролын сургуулийн спорт заал, Есөнзүйл сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын их засварууд хийгдсэн.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын засвар шинэчлэлд 230,0 сая төгрөг төсөвлөж Төгрөг, Хужирт сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар, Хайрхандулаан сумын 6 дугаар баг, Баян-Өндөр сумын 3 дугаар баг, Арвайхээр сумын багийн нэгдсэн

төвийн засварыг хийж гүйцэтгүүлэв. Улсын төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр Сант сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажлыг хийж гүйцэтгүүлэв.

Орон нутгийн төсвийн 256,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 112 багийн Засаг дарга нарыг зөөврийн компьютероор хангаж, улсын төсвийн 150,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын тоног төхөөрөмжийн шинэчлэл”-ийн ажлыг хийж, ажиллах нөхцөлийг сайжрууллаа.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

3.1. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДАЛ

3.1.1. Үйл ажиллагааны ил тод байдлын талаар

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны “Журам батлах тухай” 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2022 оны “Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай” ХЭГ/1645 дугаар албан бичгээр ирүүлсэн 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилласан байдалд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

Төрийн байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх ажлын чиглэлийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан ажилласан. Үүнд:

1. Бодлого, шийдвэрийн төсөлд санал авах
2. Бодлого, шийдвэрийг сурталчлах
3. Бодлого, шийдвэрийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх гэсэн 10 чиг үүргийн ажлуудыг гүйцэтгүүлэхээр тусгасан.

Төрийн байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх ажлын хүрээнд жил бүрийн орон нутгийн төсөвт ил тод байдлыг хангах, үйл ажиллагааг сурталчлахад чиглэсэн зардал тусгадаг. 2022 онд 90,0 сая төгрөгийг тусгаж, 11 байгууллагатай гэрээ байгуулан ажилласан.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллаганы хөтөлбөрт “Төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа сурталчлах зардлыг жил бүр төсөвтөө тусган, мэдээллийн ил тод байдлыг хангахад хяналт тавьж, иргэдэд үнэн бодит мэдээлэл түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч, “Нэг цонхны мэдээлэл” үйл ажиллагааг үр дүнтэй нэвтрүүлэх (3.2.1.7) арга хэмжээг тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төрийн үйлчилгээг иргэдэд нэг дороос тэгш, хүртээмжтэй хүргэж, иргэдээс ирсэн гомдол мэдээллийг шуурхай шийдвэрлэсэн. Үйлчилгээний нэгдсэн төвд иргэний бүртгэл, газар өмчлөл, газар эзэмшил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, эрүүл мэнд, нийгмийн даатгал, татвар, хяналтын камер, иргэдийн санал, гомдол хүлээн авах 7032-1111, цахилгаан эрчим хүч хэрэглэсний төлбөр авах цэг, угтах үйлчилгээ, операторын үйлчилгээ, номин даатгал, кадастрын зураг зэрэг төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж ажиллав.


Үйлчилгээний нэгдсэн төвд 12 чиг үүргийн 16 төрийн албан хаагч төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна. 2022 онд давхардсан тоогоор 37393 иргэнд үйлчилгээг үзүүлсэн байна.

Цаг уурын байгууллагын ирүүлсэн мэдээллийн дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газраас ард, иргэдэд урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон багц мессеж үйлчилгээгээр дамжуулан хүргэх ажлыг хэвшүүлэн ажиллаж байна.

Үйлчилгээний нэгдсэн төвийн иргэдийн гомдол, мэдээлэл хүлээн авах 7032-1111 утсанд 2022 онд нийт 548 өргөдөл гомдол ирсэн байна. Үүнээс 82 хувь нь гомдлын шинжтэй, 17 хувь нь санал хүсэлт, 1 хувь нь мэдээлэл авсан байна.

График 3.1


2022 оны жилийн эцсийн байдлаар /нийт 548/




Иргэдийн ирүүлсэн гомдол, саналыг нэгтгэн долоо хоног бүрийн Мягмар гарагт аймгийн хэлтэс алба, агентлагийнн дарга нарын шуурхай хуралд танилцуулж хэвшсэн ба 2022 онд нийт 39 удаагийн шуурхай хуралдаанд өргөдөл, гомдлыг танилцуулсан байна.

График 3.2

Нийт хандалтыг сараар авч үзвэл /548/



Иргэд өргөдөл, гомдол ирүүлсэн суваг (нийт 548)



Аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн амбулаторийн эмчийн үзлэгийн цагийг урьдчилан захиалах “CALL PRO” операторын шинэ технологийг нэвтрүүлж, 7032-3212 дугаарын утсаар ажлын өдөр бүр үзлэгийн цагийг иргэдэд өгч үйлчилж байна.

Коронавируст халдвар (ковид-19)-тай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хэрэгжиж буй tandalt.gov.mn, e-mongolia.mn, eruul.gerege.mn зэрэг цахим системд мэдээллийн санг бүрдүүлэн (ковид-19)-ын шинжилгээний хариу, дархлаажуулалтын сертификат, (ковид-19)-ын халдварын эмнэлгийн магадлагаа, QR батламжийг иргэд нэгдсэн системээс шууд авах боломжийг бүрдүүлэн ажиллав.

Аймгийн төвийн хэмжээнд нийт 54 цэгт 140 гаруй камер ажиллаж, 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналтын камерын системээс нийт 342 удаагийн бичлэг нөхөн үзсэн байна. Үүнээс хулгайн гэмт хэрэг болон эд зүйлээ хаясан гээсэн 56, замын хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн осолтой холбоотой 121, нийтийн эзэмшлийн зам талбай, хайс хашлага дайрсан 9 удаагийн камерын бичлэг шүүсэн байна. Үүнд жолооч автомашин жолоодох үедээ хамгаалах бүс хэрэглээгүй, тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцох үед

гар утас хэрэглэсэн, хүн тээвэрлэх журам зөрчсөн зэрэг нийт 156 зөрчил илрүүлэн цагдаагийн байгууллагад шилжүүлэн ажиллав.

2022 онд 14 цэгийн камерт 28 удаагийн засвар үйлчилгээг хийж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллав.


Зураг 3.1



Үйлчлүүлэгч иргэдэд төрийн үйлчилгээг хаанаас, хэрхэн авах талаар зөвлөгөө мэдээлэл хүргэн ажиллав. Мөн “Цахим Засаглал” бодлогын хүрээнд Үйлчилгээний нэгдсэн төвд байгуулсан иргэд өөртөө үйлчлэх цахим булангаар дамжуулан хэрхэн ажиллах заавар зөвлөгөөг хүргэн, EGazar, Emongolia цахим үйлчилгээний хэрэглэгч болсноор иргэдэд гэрээсээ, гар утаснаасаа төрийн аливаа үйлчилгээг оочир дугаар хүлээх шаардлагагүй болж хаанаас ч үйлчилгээгээ авах боломжтойг тайлбарлан, цахим боловсролын мэдээллийг иргэдэд түгээж байна. Цахим хөтчийн булангаар 2022 оны жилийн эцсийн байдлаар 3756 иргэн үйлчлүүлсэн байна.

Иргэдэд угтаж үйлчлэх, зөвлөн туслахаас гадна Үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлэхэд тулгарч буй хүндрэл, цаашид анхаарах асуудал, албан хаагчдын харилцаа хандлагыг тодорхойлох зэрэг сэтгэл ханамжийн судалгааг авч, улирал бүр нэгтгэн гаргадаг. Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг үндэслэн үйл ажиллагаандаа анхаарч, шинэ шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж хэвшээд байна.

Зураг 3.2



Мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах чиглэлээр

Аймаг, орон нутгийн шийдвэр, түүний хэрэгжилт, төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээ, мэдээлийг доорх мэдээллийн сувгуудаар олон нийтэд хүргэн ажиллаж байна. Үүнд:

- www.uvurkhangai.mn
- www.montsame.mn
- Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевиз, Малчин, Eagle, NTV, Монголын мэдээ сонин, Дэлхийн Монгол 88.3 радио
- Орон нутгийн 3 телевиз, 10 хоног тутмын нэг сонин, 1 цахим телевиз, 1 богино долгионы радио
- Тусгай дугаарын сонин, сэтгүүл
- Сошиал суваг зэрэг.


Аймгийн www.uvurkhangai.mn сайтыг “Төрийн байгууллагын вэб сайтад тавигдах шаардлага MNS 6285:2017 стандарт”-ын дагуу хөгжүүлж, цахим хуудасны бүтэц, зохион байгуулалт, мэдээллийн агуулгыг хэрэглэгчдэд ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байхаар хөтөлж байна.

Зураг 3.3



Үүний үр дүнд тус аймгийн вэб сайтад 2021 онд 95000 иргэн хандаж мэдээлэл авсан бол тайлант онд 139500 болж өссөн байна.

График 3.3



Иргэдийн дийлэнх хувь нь сошиал сувгийг ашиглаж мэдээлэл авч байгаатай холбогдуулан “Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар” албан ёсны нэртэй, 31000 дагагчтай пэйж хуудсыг хөтөлж, мэдээллээ нийгмийн сүлжээгээр давхар хүргэж байна.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлаг, 19 сумаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээ, аймаг, орон нутгийн бодлого чиглэлийг олон нийтэд мэдээлж сурталчлахад 2022 онд нийт 58,9 сая төгрөгийг зарцуулсан.

Аймгийн албан ёсны цахим хуудас uvurkhangai.mn сайттай 22 агентлаг, 19 сумын веб хуудсыг холбож төрийн мэдээллийг нэг цонхноос ил тод, хүртээмжтэй авах нөхцөл боломжийг ханган ажиллаж байна.

Төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн 12 байгууллагатай гэрээ байгуулж, аймгийн бодлого шийдвэр, түүний хэрэгжилтийг иргэдэд ил тод, нээлттэй хүргэхэд хамтран ажиллалаа. МҮОНТ, МҮОНР, montsame агентлаг, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг “Хас”, “Соёмбо”, “GMN-TV”, “Арвайхээр чөлөөт суваг” зэрэг 4 телевиз, “Өвөрхангайн мэдээ”, Өвөрхангай 10 хоног тутмын 2 сонин, “Ноён-Уул 102.6” богино долгионы радио, “uvnews.mn” мэдээллийн сайт, “Өв брэнд консалтинг” ХХК зэрэг нийт хэвлэл мэдээллийн 12 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, санхүүжилтийг ажлын гүйцэтгэлээр улирал бүр тооцож, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас олгов.

Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд МҮОНТ-ээр Өвөрхангай аймагтай холбоотой нийт 429 мэдээ, сурвалжилга, ярилцлага, орон нутгийн 3 телевизээр 1178 мэдээ, сурвалжилга ярилцлага, 21 нэвтрүүлэг, montsame.mn сайтаар 312 мэдээ, Малчин телевизээр 4 нэвтрүүлгийг тус тус бэлтгүүлж, олон нийтэд аймгийн бодлого шийдвэр, хэрэгжилт, үр дүнг, олон нийтэд мэдээлж сурталчиллаа.

Мөн uvurkhangai.mn сайтад цаг үеийн 195 мэдээ, Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар пэйж хуудсанд 389 мэдээг нийтлэв.

3.1.2. Хүний нөөцийн ил тод байдлын талаар

Зураг 3.4

Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах зорилгоор аймгийн албан ёсны www.uvurkhangai.mn сайтыг бүрэн динамик өргөжүүлж шинэчилсэнтэй холбогдуулан аймгийн вэб сайтад байршуулах хүний нөөцийн үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлын цэсийг “Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 6285:2016, MNS 6285:2017” стандартад нийцүүлэн шинэчилсэн.



Төрийн байгууллага, албан хаагч, иргэд, олон нийтийн зүгээс хүний нөөцийн ил тод байдлын хүрээнд ямар мэдээллийг илүү авахыг хүсэж байгаа талаар холбогдох албан хаагч тандалт хийсний үндсэн дээр аймгийн вэб сайтад төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэх тухай Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг сүүлийн 4 жилээр, Салбар зөвлөлөөс гаргасан тогтоолыг сүүлийн 5 жилээр, байгууллага, нэгж, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний батлагдсан загвар, боловсруулах аргачлал, арга зүй, Төрийн албаны хууль батлагдсантай холбогдуулан шинээр батлагдан гарсан тогтоол, шийдвэрийг байршууллаа.

Хүний нөөцийн ил тод байдлын мэдээллийг стандартын дагуу аймгийн вэб сайтад бүрэн байршуулснаар иргэд, олон нийт мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажилласны үр дүнд аймгийн цахим хуудсанд сард дунджаар 800 орчим иргэн тогтмол хандаж мэдээлэл авч байгаа нь урд оны мөн үеэс сайтын хандалт 2 дахин нэмэгджээ.

Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын болон төрийн албаны тусгай шалгалтын зарыг иргэд ойлгомжтой, хялбар байдлаар QR кодыг гар утсаараа уншуулан мэдээлэл авах боломжийг бий болгож, уг кодыг аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбар, төрийн байгууллагуудын цахим социал хуудаст байршуулж ажиллав.

Тайлант хугацаанд төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын зар, төрийн албаны ерөнхий шалгалтын зар, төрийн албаны тусгай шалгалтын зарыг Төрийн албаны зөвлөл болон аймгийн вэб сайт, Үйлчилгээний нэгдсэн

төвөөр мэдээлж, Төрийн албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөл, Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар, төрийн бусад байгууллагуудын социал цахим хуудаст байршуулан шалгалтын талаарх мэдээллийг ил тод нээлттэй, шуурхай хүргэж ажиллав.

Зураг 3.5



Аймгийн хэмжээнд төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй иргэдийн мэдээллийг uvirkhangai.mn цахим хуудасны ИЛ ТОД цэсний ХҮНИЙ НӨӨЦ дотор “Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэх тухай” 2019 оны 359 дүгээр тогтоол, 2020 оны 371 дүгээр тогтоол, 2021 оны 106 дугаар тогтоол, 2021 оны 362 дугаар тогтоол, 2022 оны 263 дугаар тогтоол, 581 дүгээр тогтоолыг тус тус байршуулснаар нөөцөд бүртгэгдсэн тогтоолоо татаж авах боломжтой болсон.

Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын “Ил тод байдлын шалгуур үзүүлэлт”-ийн “Хүний нөөцийн ил тод байдал”-ын 5 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 100,0 хувь буюу 5,0 оноотой дүгнэгдсэн.

Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, чадавхжуулах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны А/561 дүгээр захирамжаар “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг баталсан.

Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын 2 дахь заалтын дагуу аймгийн Засаг даргын 2021 оны А/342 дугаар захирамжаар “Бодлогын

баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, салбар зөвлөлд ирүүлсэн хугацаатай мэдээ, тайлангийн чанар, үр дүн зэрэг үзүүлэлтийг тусган төрийн байгууллагуудын жилийн эцсийн үнэлгээнд харгалзуулж байна.

Төрийн байгууллага, албан хаагч, иргэд, олон нийтийн зүгээс хүний нөөцийн ил тод байдлын хүрээнд ямар мэдээллийг илүү авахыг хүсэж байгаа талаар холбогдох албан хаагч тандалт хийсний үндсэн дээр аймгийн вэб сайтад төрийн жинхэнэ албан тушаалын нөөцөд бүртгэгдсэн иргэдийн жагсаалт, нөөцөд бүртгэсэн тогтоолыг сүүлийн 4 жилээр, удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтын зар, салбар зөвлөлийн тогтоол, байгууллага, нэгж, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний батлагдсан загвар, боловсруулах аргачлал, арга зүй, Төрийн албаны хууль батлагдсантай холбогдуулан шинээр батлагдан гарсан тогтоолыг жил бүр байршуулж хэвшээд байна.

Тайлант хугацаанд төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн



сонгон шалгаруулалтын зар, төрийн албаны ерөнхий шалгалтын зар, төрийн албаны тусгай шалгалтын зарыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, Төрийн албаны зөвлөл болон аймгийн вэб сайт, Боловсрол, шинжлэх ухааны газрын вэб сайт, Үйлчилгээний нэгдсэн төвөөр мэдээлж, байгууллагын мэдээллийн самбарт байршуулан, шалгалтын талаарх мэдээлэл авах боломжоор хангаж ажиллав. Авлигатай тэмцэх газраас хүний

нөөцийн томилгоо, сонгон шалгаруулалтын зар, түүний үр дүн, салбар зөвлөлийн үйл ажиллагаа, шийдвэрийн ил тод нээлттэй байдалд жил бүр хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэж ажиллалаа.

Зураг 3.6



Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” 143 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2022 оны “Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай” ХЭГ/1645 дугаар албан бичгээр ирүүлсэн 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилласан.

Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг хуулийн 18.1.7-д заасны дагуу төрийн үйлчилгээ, авлигын эсрэг үйл ажиллагааны судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинг 2 жил тутамд үнэлгээ хийж, олон нийтэд мэдээлдэг. 2022 оны үнэлгээгээр Өвөрхангай аймаг нь шударга байдлын түвшин 77,6 хувьтай 21 аймгаас 5 дугаарт эрэмбэлэгдсэн.

3.1.3.Худалдан авах ажиллагааны ил тод байдлын талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд 2022 онд нийт 71,445.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 78 төсөл арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [tender.gov.mn/-ээр](http://tender.gov.mn/) иргэд, олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

Орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, авто замын сан, зээл тусламж, байгууллагын захиалгаар зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.6, 3.9-д заасны дагуу цахим системээр хянан, баталж Төрийн захиргааны төв байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлсэн байна.

Тайлант онд зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны сургалтад хөндлөнгийн төлөөлөл болох 11 хүн хамрагдсанаас 7 иргэн шинээр сертификат авсан байна. Мөн худалдан авах ажиллагаанд оролцож буй төрийн албан хаагч, хөндлөнгийн төлөөллүүдийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтад хамруулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгууллаа.

2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 71,445.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 78 төсөл арга хэмжээг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулсан. Нийт төсөл арга хэмжээг босго үнээс нь хамааруулан нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу 44, тендер шалгаруулалтын онцгой журмаар 32, зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтаар 2 төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

3.2.ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТ.


Төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч нь шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тавих¹ үүргийн хүрээнд Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” 29 дүгээр тогтоолын дагуу шилэн дансны мэдээллийг www.shilendans.gov.mn цахим санд тогтмол байршуулж байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах 173 төсвийн байгууллага, 20 Төрийн сан, хувь оролцоотой болон төрийн өмчит хувьцаат компани-1, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар-3, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар-5 нийт 202 байгууллага Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээ тайланг хуулийн хугацаанд байршуулж байна.

Эдгээр байгууллага нь 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар шилэн дансны цахим системд нийт 31508 мэдээлэл байршуулах ёстойгоос 92,9% буюу 29259 мэдээллийг хуулийн хугацаанд, 6,2% буюу 1953 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол 0,9% буюу 296 мэдээлэл огт байршуулаагүй байна.

Эндээс харахад мэдээлэл байршуулалт 99.1 хувьтай буюу хуулийн хэрэгжилт хангалттай гэж дүгнэж болохоор байна.

График 3.4



Эх сурвалж: Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны жилийн эцсийн тайлангийн мэдээлэл.

¹ Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэл оруулах эрх бүхий хуулийн этгээд

График 3.5



Шилэн дансны тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш мэдээлэл байршуулах ёстой төсвийн болон аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээд мэдээллийг бүрэн байршуулж хэвшсэн, дээд шатны байгууллагад илгээх, дамжуулахдаа хугацаа хоцроох зэрэг асуудлууд байсаар байна.

Гэвч мэдээллийг оруулаад илгээхээ мартдаг, мэддэггүй, эсвэл хугацааны сүүлийн өдрөө тулган хандах зэргээс шалтгаалан системийн ачаалал ихэссэнээс хоцрох, тасрах зэрэг тохиолдол гарсаар байна. Үүнд холбогдох хяналт шалгалтын байгууллагын зүгээс анхааран ажиллаж мэргэшил арга зүйн зөвлөгөөг байнга өгч ажилладаг.

Улсын хэмжээнд шилэн дансны нэгдсэн хуудасны хэрэгжилт 95,0 хувьтай байгаа ба манай аймаг 99,1 хувьтай байгаа нь сайн үзүүлэлт юм.

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллага, гэрээний үндсэн дээр ажил үйлчилгээ гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагын байршуулсан мэдээллийг төрлөөр нь ангилан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Өвөрхангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяа байгууллагуудын 2022 оны Шилэн дансны мэдээлэл:

Хүснэгт 3.1

№	Засгийн газрын тусгай сан, бусад сангууд	Мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорсон
1	Баян-Өндөр сум	160	159	158	1
2	Бүрд сум	160	159	116	43
3	Бат-Өлзий сум	160	158	158	
4	Баруунбаян-Улаан сум	160	160	159	1
5	Баянгол сум	160	160	154	6
6	Гучин-Ус сум	160	158	144	14
7	Есөнзүйл сум	160	159	159	
8	Өлзийт сум	160	160	159	1
9	Зүүнбаян-Улаан сум	160	160	157	3
10	Богд сум	160	160	96	64
11	Нарийнтээл сум	160	160	148	12
12	Сант сум	160	158	158	
13	Тарагт сум	160	160	155	5
14	Төгрөг сум	160	160	157	3
15	Уянга сум	160	158	158	
16	Хайрхандулаан сум	160	159	159	
17	Хужирт сум	160	160	160	
18	Хархорин сум	160	159	146	13
19	Арвайхээр сум	172	172	168	4
20	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс	160	160	135	25
ДҮН		3212	3199	3004	195
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУД:					
1	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	156	155	146	9
2	Биеийн тамир, спортын газар	156	156	156	0
3	Аймгийн музей	156	156	155	1
4	Аймгийн номын сан	156	156	153	3
5	Хөгжимт драмын театр	156	156	153	3
6	Төрийн үйлчилгээний нэгдсэн төв	156	155	153	2
7	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	156	156	136	20
8	Сум дундын ойн анги	156	156	156	0
9	Насан туршийн боловсрол төв	156	156	144	12
10	Мэргэд цогцолбор сургууль	156	156	154	2
11	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	141	15
12	Аймгийн Засаг даргын Тамгын газар	156	156	151	5
13	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	156	156	144	12
14	Орон нутгийн өмчийн газар	156	156	151	5
15	Усан спорт сургалтын төв	156	156	142	14
16	Соёл, урлагийн газар	156	156	133	23
17	Гэр бүл, хүний хөгжлийн төв	156	155	155	0
18	Ахмадын хороо	156	156	138	18

19	Бүрд сумын ерөнхий боловсролын сургууль	156	156	142	14
20	Бүрд сумын цэцэрлэг	156	156	136	20
21	Бүрд сумын Эрүүл мэндийн төв	156	156	155	1
22	Бүрд сумын Соёлын төв	156	156	156	0
23	Бүрд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	156	0
24	Бүрд сумын Засаг даргын Тамгын газар	156	156	156	0
25	Бат-Өлзий сумын ерөнхий боловсролын сургууль	156	133	129	4
26	Бат-Өлзий сумын цэцэрлэг	156	156	127	29
27	Бат-Өлзий сумын 2 дугаар цэцэрлэг	156	156	120	36
28	Бат-Өлзий сумын хүн эмнэлэг	156	156	134	22
29	Бат-Өлзий сумын Соёлын төв	156	156	156	0
30	Бат-Өлзий сум иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	156	0
31	Бат-Өлзий сум Засаг даргын Тамгын газар	156	156	155	1
32	Баруунбаян-Улаан сумын ерөнхий боловсролын сургууль	156	156	149	7
33	Баруунбаян-Улаан сумын цэцэрлэг	156	156	147	9
34	Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төв	156	154	146	8
35	Баруунбаян-Улаан сумын Соёлын төв	156	156	146	10
36	Баруунбаян-Улаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	135	21
37	Баруунбаян-Улаан сум Засаг даргын Тамгын газар	156	156	135	21
38	Баянгол сумын ерөнхий боловсролын сургууль	156	156	155	1
39	Баянгол сумын цэцэрлэг	156	156	155	1
40	Баянгол сумын Эрүүл мэндийн төв	156	156	153	3
41	Баянгол сумын Соёлын төв	156	156	152	4
42	Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	98	58
43	Баянгол сумын Засаг даргын Тамгын газар	156	156	106	50
44	Гучин-Ус сумын ерөнхий боловсролын сургууль	156	156	143	13
45	Гучин-Ус сумын цэцэрлэг	156	156	144	12
46	Гучин-Ус сумын Эрүүл мэндийн төв	156	156	131	25
47	Гучин-Ус сумын Соёлын төв	156	156	142	14
48	Гучин-Ус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	156	0
49	Гучин-Ус сумын Засаг даргын Тамгын газар	156	156	155	1
50	Есөнзүйл сумын ерөнхий боловсролын сургууль	156	156	152	4
51	Есөнзүйл сумын цэцэрлэг	156	155	150	5
52	Есөнзүйл сумын Эрүүл мэндийн төв	156	156	133	23
53	Есөнзүйл сумын Соёлын төв	156	156	150	6
54	Есөнзүйл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	156	0
55	Есөнзүйл сумын Засаг даргын Тамгын газар	156	156	155	1
56	Өлзийт сумын ерөнхий боловсролын сургууль	156	154	154	0
57	Өлзийт сумын цэцэрлэг	156	155	150	5
58	Өлзийт сумын Эрүүл мэндийн төв	156	154	154	0
59	Өлзийт сумын Соёлын төв	156	156	154	2

60	Өлзийт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	147	9
61	Өлзийт сум Засаг даргын Тамгын газар	156	156	138	18
62	Зүүнбаян-Улаан сумын ерөнхий боловсролын сургууль	156	154	139	15
63	Зүүнбаян-Улаан сумын цэцэрлэг	156	155	144	11
64	Зүүнбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төв	156	156	144	12
65	Зүүнбаян-Улаан сумын Соёлын төв	156	156	143	13
66	Зүүнбаян-Улаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	155	142	13
67	Зүүнбаян-Улаан сум Засаг даргын Тамгын газар	156	155	140	15
68	Хайрхандулаан сумын ерөнхий боловсролын сургууль	156	156	155	1
69	Хайрхандулаан сумын цэцэрлэг	156	156	155	1
70	Хайрхандулаан сумын Эрүүл мэндийн төв	156	155	147	8
71	Хайрхандулаан сумын Соёлын төв	156	156	146	10
72	Хайрхандулаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	146	10
73	Хайрхандулаан сумын Засаг даргын Тамгын газар	156	156	144	12
74	Нарийнтээл сумын ерөнхий боловсролын сургууль	156	156	152	4
75	Нарийнтээл сумын Баянтээг сургууль	156	152	134	18
76	Нарийнтээл сумын цэцэрлэг	156	156	151	5
77	Нарийнтээл сумын Баянтээг цэцэрлэг	156	152	135	17
78	Нарийнтээл сумын Эрүүл мэндийн төв	156	156	152	4
79	Нарийнтээл сумын Баянтээг эмнэлэг	156	156	120	36
80	Нарийнтээл сумын Соёлын төв	156	112	74	38
81	Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	153	3
82	Нарийнтээл сумын Засаг даргын Тамгын газар	156	110	66	44
83	Сант сумын ерөнхий боловсролын сургууль	156	156	145	11
84	Сант сумын цэцэрлэг	156	154	128	26
85	Сант сумын эрүүл мэндийн төв	156	156	135	21
86	Сант сумын Соёлын төв	156	155	148	7
87	Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	155	144	11
88	Сант сумын Засаг даргын Тамгын газар	156	155	134	21
89	Тарагт сумын ерөнхий боловсролын сургууль	156	156	156	0
90	Тарагт сумын Туяа бага сургууль	156	156	152	4
91	Тарагт сумын цэцэрлэг	156	156	156	0
92	Тарагт сум Эрүүл мэндийн төв	156	156	153	3
93	Тарагт сумын Соёлын төв	156	156	152	4
94	Тарагт сум иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	146	10
95	Тарагт сумын Засаг даргын Тамгын газар	156	155	143	12
96	Төгрөг сумын ерөнхий боловсролын сургууль	156	155	154	1
97	Төгрөг сумын цэцэрлэг	156	156	154	2
98	Төгрөг сумын Эрүүл мэндийн төв	156	156	145	11
99	Төгрөг сум Соёлын төв	156	156	151	5

100	Төгрөг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	148	8
101	Төгрөг сумын Засаг даргын Тамгын газар	156	156	141	15
102	Уянга сумын 1 дүгээр сургууль	156	156	153	3
103	Уянга сумын Жаргалантын 8 жил	156	156	152	4
104	Уянга сумын 2 дугаар сургууль	156	156	145	11
105	Уянга сумын цэцэрлэг	156	156	155	1
106	Уянга сумын 2 дугаар цэцэрлэг	156	156	154	2
107	Уянга сумын Жаргалантын цэцэрлэг	156	156	152	4
108	Уянга сумын Эрүүл мэндийн төв	156	156	148	8
109	Уянга сумын Жаргалант баг эмнэлэг	156	155	89	66
110	Уянга сумын Соёлын төв	156	156	155	1
111	Уянга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	154	151	3
112	Уянга сумын Засаг даргын Тамгын газар	156	154	151	3
113	Богд сумын ерөнхий боловсролын сургууль	156	155	154	1
114	Богд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	49	36	32	4
115	Богд сумын цэцэрлэг	156	156	152	4
116	Богд сумын 2 дугаар цэцэрлэг	156	155	154	1
117	Богд сумын Эрүүл мэндийн төв	156	156	152	4
118	Богд сумын Соёлын төв	156	155	155	0
119	Богд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	155	155	0
120	Богд сумын Засаг даргын Тамгын газар	156	155	155	0
121	Хужирт сумын ерөнхий боловсролын сургууль	156	155	153	2
122	Хужирт сумын 1 дүгээр цэцэрлэг	156	156	154	2
123	Хужирт сумын 2 дугаар цэцэрлэг	156	156	155	1
124	Хужирт сумын 3 дугаар цэцэрлэг	156	156	154	2
125	Хужирт сумын 4 дүгээр цэцэрлэг	156	154	153	1
126	Хужирт сумын эрүүл мэндийн төв	156	156	152	4
127	Хужирт сумын Соёлын төв	156	156	154	2
128	Хужирт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	142	14
129	Хужирт сумын Засаг даргын Тамгын газар	156	156	141	15
130	Хархорин сумын 1 дүгээр сургууль	156	155	138	17
131	Хархорин сумын 2 дугаар сургууль	156	155	139	16
132	Хархорин сумын 3 дугаар сургууль	156	155	114	41
133	Хархорин сумын 1 дүгээр цэцэрлэг	156	155	144	11
134	Хархорин сумын 2 дугаар цэцэрлэг	156	154	105	49
135	Хархорин сумын Хархорин цогцолбор цэцэрлэг	156	155	138	17
136	Хархорин сумын 4 дүгээр цэцэрлэг	156	156	156	0
137	Хархорин сумын 5 дугаар цэцэрлэг	156	156	156	0
138	Хархорин сумын Эрдэнэзуу музей	156	156	156	0
139	Хархорин сумын Соёлын төв	156	154	154	0
140	Хархорин сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	156	0
141	Хархорин сум Засаг даргын Тамгын газар	156	154	154	0
142	Хархорин Спортын ордон	156	154	154	0
143	Монголын бурхан шашны дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	156	153	153	
144	Арвайхээр сумын 1 дүгээр сургууль	156	155	147	8

145	Арвайхээр сумын ерөнхий боловсролын Тэмүүлэл эрдэм сургууль	156	156	155	1
146	Арвайхээр сум Соёмбо цогцолбор сургууль	156	154	150	4
147	Арвайхээр сумын 4 дүгээр сургууль	156	155	147	8
148	Арвайхээр сумын 5 дугаар сургууль	156	156	151	5
149	Арвайхээр сумын 1 дүгээр цэцэрлэг	156	156	155	1
150	Арвайхээр сумын 2 дугаар цэцэрлэг	156	155	151	4
151	Арвайхээр сумын 3 дугаар цэцэрлэг	156	154	144	10
152	Арвайхээр сумын 4 дүгээр цэцэрлэг	156	155	150	5
153	Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэг	156	156	153	3
154	Арвайхээр сумын 6 дугаар цэцэрлэг	156	154	151	3
155	Арвайхээр сумын 7 дугаар цэцэрлэг	156	156	156	0
156	Арвайхээр сумын 8 дугаар цэцэрлэг	156	156	155	1
157	Арвайхээр сумын 9 дүгээр цэцэрлэг	156	154	152	2
158	Арвайхээр сумын 10 дугаар цэцэрлэг	156	156	153	3
159	11 дүгээр тусгай цэцэрлэг	156	155	143	12
160	Арвайхээр сумын 12 дугаар цэцэрлэг	156	154	147	7
161	Арвайхээр сумын 13 дугаар цэцэрлэг	156	156	154	2
162	Арвайхээр сумын 14 дүгээр цэцэрлэг	156	155	149	6
163	Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	155	1
164	Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар	156	155	149	6
165	Арвайхээр сумын Түшиг Дөлгөөн ББН	156	156	133	23
166	Арвайхээр сумын Уян сэтгэл	156	156	152	4
167	Арвайхээр сумын Нарны дөш	156	156	133	23
168	Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль	156	156	154	2
169	Баян-Өндөр сумын цэцэрлэг	156	156	151	5
170	Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төв	156	156	144	12
171	Баян-Өндөр сумын Соёлын төв	156	156	150	6
172	Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	156	156	156	0
173	Баян-Өндөр сум Засаг даргын Тамгын газар	156	156	152	4
ДҮН		26881	26677	25128	1549

ТӨХК, ОНӨҮГ, ОНӨААТҮГ, ТӨҮГ-ууд:

Хүснэгт 3.2

№	ОНӨХК-ийн мэдээлэл	Мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорсон
1	Хархорин ус суваг	154	154	153	1
2	Онги-Ус Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	154	154	117	37
3	Арвайхээр сумын Төхижилт үйлчилгээ орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	154	154	154	
4	Нарийнтээл сум, Баянтээг ХК түлш	183	158	121	37

5	Арвайхээр сумын Цэцэрлэгжилт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	154	154	154	
6	Хужирт эрдэс баялаг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	154	153	148	5
7	Өв эко мийт орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	154	102	28	74
8	Арвайхээр хотын нийтийн тээвэр, гэрэлтүүлэг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	154	153	142	11
9	Өв-агро гурил тэжээлийн үйлдвэр ХХК	154	154	110	44
<i>ДҮН</i>		1415	1336	1127	209

Эх сурвалж: Shilendans.gov.mn, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба

Шилэн дансны тухай хуулийн 8.2²-т Төсвийн ерөнхийлөн захирагч (дотоод аудитын алба) нь шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана гэж заасны дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг дансны хуулгатай тулган хяналт тавин ажилласан болно.

Шилэн дансанд байршуулсан мэдээллүүдээс харахад гүйлгээ гараагүй сард хоосон хүснэгт хавсаргадаг, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг бүрэн бичдэггүй, тайлан мэдээг улирал, хагас, бүтэн жилээр оруулах мэдээллийг оруулахгүй орхигдуулдаг зэрэг зөрчил илэрсээр байна.

Дээрх зөрчил дутагдлыг удаа дараа гаргасан төрийн албан хаагчдад аймгийн Засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн “Хариуцлага тооцох, урамшуулал олгох тухай” А/192 дугаар захирамжаар 13 төсвийн шууд захирагч болон нягтлан бодогч нарт “Сануулах” сахилгын арга хэмжээ тооцсон байна.

Төсвийн захирагч, нягтлан бодогч нарт сахилгын арга хэмжээ тооцож байгаа ч шилэн дансны хөтлөлт урд онуудаас өссөн үзүүлэлттэй гарч байгаа нь хариуцлага сайжирч байгаагийн илрэл юм.

Төрийн Аудитын газраас сүүлийн жилүүдийн (2016, 2017, 2018) Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх төлөвлөгөөт хяналтын тайлангаар “Хангалттай” сайн буюу хуулийн хэрэгжилтийн хувь өсөж байна гэж үнэлсэн ба 2020, 2021, 2022 онуудад жилийн эцсийн санхүүгийн тайлантай хамт шилэн дансны нэгдсэн системд мэдээлэл оруулж байгаад давхар хяналт тавин албан шаардлага хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан болно.

Мөн 2022 оны 2 дугаар улирлаас эхлэн системийн шинэчлэл хийгдэж 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн шинэчилсэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг ашиглаж, ингэснээр татвар, эрхийн бүртгэлийн сан зэрэг нэвтрэлтийн нэгдсэн системээр хандан аливаа тайлан, мэдээний уялдаа холбоо сайжрах нөхцөл бүрдэж байна.

Зөвлөмж

-Нийтлэг гарч буй алдааг давтан гаргахгүй байхыг бүх шатны төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагууд, мэдээлэл оруулах эрх бүхий албан хаагчид анхааран ажиллаж хариуцлагатай байх;

² 8.2.Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.

-Төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт оруулах мэдээллийг бүрэн оруулж байхыг холбогдох хуулийн этгээдэд шаардлага тавин аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албатай хамтран ажиллах, мэргэшлийн зөвлөгөө өгөх;

-Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг бүрэн оруулж ажиллахад анхаарах.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

3.3.ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИН

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д “Төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудын 2022 оны “Шударга байдлын үнэлгээ”-г зохион байгуулан, үр дүнг ирүүлсэн.

Ерөнхий үнэлгээ

Авлигатай тэмцэх газрын ирүүлсэн дүнгээр Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2022 оны “Шударга байдлын үнэлгээ”-ний ерөнхий үнэлгээгээр 77,6 хувьтай үнэлэгдэж 21 аймгаас 5 дугаарт эрэмбэлэгдсэн байна.³ Ерөнхий үнэлгээ нь 2021 оны үнэлгээ 78,4 хувиас 0,8 пунктээр буурсан хэдий ч улсын дунджаас 3,7 хувиар өссөн үзүүлэлттэй, мөн хангайн бүсийн аймгуудаас 2 дугаарт эрэмбэлэгдэж байна. (Зураг 3.9-өөс үзнэ үү.)

Зураг 3.7

График 6. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ШБҮ, 2022 он, оноогоор



Дээрх “Шударга байдлын үнэлгээ”-г төрийн байгууллагын дотоод шударга байдал, гадаад шударга байдал, бодлогод оролцогч шинжээчдийн үнэлгээ гэсэн 3 үндсэн агуулга бүхий 65 дэд үзүүлэлтээр тогтоосон байна.

Дотоод шударга байдлын үнэлгээ

Судалгааны үр дүнг нарийвчлан авч, дүн шинжилгээ хийж үзвэл “Дотоод шударга байдал буюу байгууллагын ажилтан, албан хаагчдын үнэлгээ”-ний үзүүлэлтээр 2021 онд 77,6 хувьтай үнэлэгдэж байсан бол 2022 онд 87,7 хувьтай үнэлэгдэн урд оноос 10,1 хувиар өссөн байна. Энэ нь аймгуудаас 4 дүгээрт эрэмбэлэгдэж, хангайн бүсийн аймгуудаа тэргүүлсэн үзүүлэлт байна.⁴ (Зураг 3.10-аас үзнэ үү.)

³ Авлигатай тэмцэх газар “Шударга байдлын үнэлгээ-2022” судалгааны тайлан. 28 дугаар нүүр

⁴ Авлигатай тэмцэх газар. “Шударга байдлын үнэлгээ-2022” судалгааны тайлан. 43 дүгээр нүүр

Зураг 3.8

Хүснэгт 16. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ДШБҮ, 2021, 2022 оныг харьцуулсан үнэлгээ

№	Байгууллагын нэр	2021	2022	Өөрчлөлт
Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ДШБҮ		80.8	82.4	↑ 1.6
1	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	82.0	92.4	↑ 10.4
2	Төв аймгийн ЗДТГ	80.0	89.6	↑ 9.6
3	Дорноговь аймгийн ЗДТГ	83.0	87.9	↑ 4.9
4	Өвөрхангай аймгийн ЗДТГ	77.6	87.7	↑ 10.1
5	Дундговь аймгийн ЗДТГ	82.1	87.7	↑ 5.6
6	Орхон аймгийн ЗДТГ	79.8	86.9	↑ 7.1
7	Увс аймгийн ЗДТГ	81.6	86.6	↑ 5.0
8	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	82.8	86.3	↑ 3.5
9	Нийслэлийн ЗДТГ	78.4	85.0	↑ 6.6

Гадаад шударга байдлын үнэлгээ

“Гадаад шударга байдал буюу тухайн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн үнэлгээ”-гээр 2021 онд 70,9 хувь байсан бол 2022 онд 78,0 хувьтай үнэлэгдэж урд оноос 7,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь аймгуудаас 4 дүгээр байр, хангайн бүсийн аймгуудаа мөн тэргүүлсэн үзүүлэлттэй байна.⁵ (Зураг 3.11-ээс үзнэ үү.)

Зураг 3.9

Хүснэгт 11. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ГШБҮ, 2021, 2022 оныг харьцуулсан үнэлгээ, оноогоор

№	Байгууллагын нэр	2021	2022	Өөрчлөлт
Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын ГШБҮ		67.4	65.4	↓ -2.0
1	Төв аймгийн ЗДТГ	71.6	86.5	↑ 15.0
2	Завхан аймгийн ЗДТГ	66.5	80.4	↑ 13.9
3	Сүхбаатар аймгийн ЗДТГ	72.3	78.2	↑ 5.9
4	Өвөрхангай аймгийн ЗДТГ	70.9	78.0	↑ 7.1
5	Архангай аймгийн ЗДТГ	68.0	76.6	↑ 8.6
6	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	61.3	74.3	↑ 13.0
7	Орхон аймгийн ЗДТГ	79.6	72.0	↓ -7.5

1.4.Бодлогод оролцогчдын үнэлгээ

“Бодлогод оролцогч шинжээчдийн үнэлгээ” буюу авлигын талаарх төсөөлөл, бодит тохиолдол, авлигыг хянах механизм, авлигаас ангид байх удирдлагын хүсэл эрмэлзлийн үзүүлэлтээр 2021 онд 79,0 байсан бол 2022 онд 67,1 хувьтай үнэлэгдэж өмнөх оноос 11,8 хувиар буурсан үзүүлэлттэй дүгнэгдсэн байна.⁶ Уг үзүүлэлтийн хувьд үнэлгээ буурсан боловч хангайн бүсийн аймгуудаас 2 дугаарт эрэмбэлэгдэж байна. (Зураг 3.12-оос үзнэ үү.)

Зураг 3.10

Хүснэгт 22. ЗДТГ - уудын БОУ, 2021, 2022 оныг харьцуулсан байдлаар

№	Байгууллагын нэр	2021	2022	Өөрчлөлт
Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын БОУ		65.9	65.5	↓ -0.4
1	Дорноговь аймгийн ЗДТГ	60.8	79.2	↑ 18.4
2	Завхан аймгийн ЗДТГ	67.7	77.9	↑ 10.2
3	Увс аймгийн ЗДТГ	67.4	75.7	↑ 8.3
4	Орхон аймгийн ЗДТГ	70.2	74.9	↑ 4.7
5	Хэнтий аймгийн ЗДТГ	79.8	74.0	↓ -5.8
6	Нийслэлийн ЗДТГ	68.6	71.2	↑ 2.6
7	Өмнөговь аймгийн ЗДТГ	65.5	70.3	↑ 4.8
8	Дархан-Уул аймгийн ЗДТГ	69.6	69.5	↓ -0.0
9	Төв аймгийн ЗДТГ	71.9	68.6	↓ -3.3
10	Дундговь аймгийн ЗДТГ	63.8	68.5	↑ 4.7
11	Өвөрхангай аймгийн ЗДТГ	79.0	67.1	↓ -11.8
12	Булган аймгийн ЗДТГ	59.9	66.7	↑ 6.8
13	Баянхонгор аймгийн ЗДТГ	61.8	63.9	↑ 2.1


1.5. Үнэлгээний сүүлийн 2 жил

Үнэлгээг сүүлийн 2 жилээр авч үзвэл аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2021 онд 78,4%-тай үнэлэгдэн аймгуудын түвшинд 2 дугаар байр, 2022 онд 77,6 хувьтай үнэлэгдэж, 21 аймгаас 5 дугаар байрт эрэмбэлэгдэн, хангайн бүсийн аймгуудаа тэргүүлсэн байна. (Графикаар үзүүлэв.)

⁵ Авлигатай тэмцэх газар “Шударга байдлын үнэлгээ-2022” судалгааны тайлан. 34 дүгээр нүүр

⁶ Авлигатай тэмцэх газар. “Шударга байдлын үнэлгээ-2022” судалгааны тайлан. 52 дугаар нүүр

График 3.6

**Дүгнэлт**

Байгууллагын 2022 оны “Шударга байдлын үнэлгээ”-ний ерөнхий үзүүлэлт 2021 оноос 0,8 хувиар буурсан хэдий ч 2022 оны улсын дунджаас 3,7 хувиар өссөн, хангайн бүсийн аймгуудаас 2 дугаарт эрэмбэлэгдсэн зэрэг эерэг үзүүлэлттэй байна.


2.1.Дээрх үнэлгээгээр хамгийн өндөр буюу 87,7 оноо авсан “Дотоод шударга байдал” 2021 оноос 10,1 хувиар өссөн нь судалгаанд оролцогчид буюу байгууллагад ажиллаж буй албан хаагчдын зүгээс байгууллага болон түүний удирдлагад өгч буй үнэлгээ, сэтгэл ханамж харьцангуй өндөр байж байгууллагын ерөнхий үнэлгээ өсөхөд шууд нөлөөлсөн байна.

2.2.Мөн “Гадаад шударга байдал”-ын үнэлгээ 70,9 хувьтай байгаа нь 2021 оноос 7,1 хувиар өссөн бөгөөд байгууллагын 2022 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд мөн Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2022 оны ХЭГ/1645 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан нь үр дүнд хүрснийг судалгааны дүн харуулж байна.

2.3.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн орон нутагт хамаарах заалтын хүрээнд 2022 оны төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүнг 2022 оны 12 дугаар сард аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 95,0 хувьтай дүгнэгдсэн.

2.4.Буурсан үзүүлэлттэй буюу 67,1 хувийн үнэлгээтэй “Бодлогод оролцогч шинжээчийн үнэлгээ”-нд дүгнэлт хийн, харьяа дээд байгууллагын төлөөлөл, бодлого боловсруулагч болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшил, холбоод, эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллах, энэ чиглэлээр онцгойлон анхаарч, цаашид тодорхой үр дүн бүхий ажил, арга хэмжээ зохион байгуулж ажиллах шаардлагатай нь харагдаж байна. (Графикаар үзүүлэв.)

График 3.7



Зөвлөмж

3.1.“Бодлогод оролцогчдын үнэлгээ”-ний үзүүлэлтийг сайжруулах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг төлөвлөн, харьяа дээд байгууллагын төлөөлөл, бодлого боловсруулагч болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшил, холбоод, эрдэмтэн, судлаачдын төлөөлөлтэй хамтран ажиллах, байгууллагын болон холбогдох нэгжийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллах.

3.2.“Дотоод шударга байдлын үнэлгээ”, “Гадаад шударга байдлын үнэлгээ”-гээ бататган, 2022 оны ерөнхий үнэлгээ буюу 77,6 хувиа ахиулах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлэн ажиллах.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГТ ТУССАН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

4.1.ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр

Өвөрхангай аймаг нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 2022 оныг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07/04 дүгээр тогтоолоор “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах” жил болгон зарлаж, зорилтот жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт, 35 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллав.

Зорилтот жилийн нээлт болон “Тэрбум мод” аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулав.

Зураг 4.1



иргэдийн төлөөлөл нийт 250 хүн оролцлоо. Энэ үеэр мод бут тарих, хог хаягдлын менежментийг сайжруулах, агро ойжуулалтын чиглэлээр сургалтууд, “Эко үзэсгэлэн” зохион байгуулагдаж, нийт 17 аж ахуйн нэгж, иргэн оролцож, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод, бут тарих аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах, ногоон зээлийн санамж бичигт гарын үсэг зурах зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулж ажилласан.

Болзолт уралдааныг зарлаж, шагнаж урамшуулав.

Зураг 4.2

“Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах” зорилтот жилийн хүрээнд шилдэг тохижилт, ногоон байгууламжтай “Сум”, “Байгууллага, аж ахуйн нэгж”, “Айл өрх”, “Сургууль, цэцэрлэг”-



ийг шалгаруулах нийт 20,6 сая төгрөгийн шагналын сантай болзолт уралдааныг зарлан шилдгүүдийг тодруулж, шагнаж урамшуулав.

Бүх сумдад соёл амралтын болон цэцэрлэгт хүрээлэнгүүдийг шинээр байгуулах, өргөтгөн шинэчлэх ажлыг зохион байгуулав.

Арвайхээр сумын шинэ суурьшлын бүсэд 12 га талбай бүхий “Их Монгол” цэцэрлэгт хүрээлэнг байгуулж, хашаажуулан 14,0 мянга орчим мод тарьж, гүний худаг гаргуулав. Энэ хүрээнд “Их Монгол цэцэрлэгт хүрээлэн”-ийн гадна цахилгаан, дэд станц, дугуйн зам, цэвэр, бохир усны шугамын ажлууд ирэх онд хийгдэхээр гэрээ байгуулагдсан.

Зураг 4.3



“Залуус”, “Моби гарден”, “Өлзийт овоо” зэрэг бичил цэцэрлэгт хүрээлэнгүүд байгуулах ажлыг эхлүүлэв.

Хархорин сум орон нутгийн төсвийн 88,7 сая төгрөгийн хөрөнгөөр хүүхдийн паркийн зориулалттай 2,3 га газрын зураг төсвийг хийлгэж, хашаажуулж, Хужирт, Баянгол, Сант, Өлзийт сумд бичил цэцэрлэгт хүрээлэн шинээр байгуулж, бусад сумд цэцэрлэгт хүрээлэндээ нэмж мод бут тарих, тохижуулах ажлууд хийгдэж, аймгийн хэмжээнд шинээр цэцэрлэгт хүрээлэн 1, бичил ногоон байгууламж 13 байгуулагдлаа.

Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд аймаг, орон нутгийн төсвөөс 1552,0 сая, улсын төсвөөс 90,0 сая, төсөл хөтөлбөр, хувийн хэвшлээс 748,0 сая, нийт 2,3 тэрбум төгрөг зарцуулж, аймгийн хэмжээгээр төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ өмнөх оны суурь түвшингээс 31 га талбайгаар нэмэгдэж, 176 га боллоо.

Мод үржүүлгийн газруудад дэмжлэг үзүүлэв.

Зураг 4.4

Зорилтот жилийн хүрээнд орон нутагт мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн чадавхыг бэхжүүлэхээр хангай, тал хээр, говиор бүсчилэн Арвайхээр цэцэрлэгжилт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, “Сум дундын ойн анги”, “Өгөөмөр шунхлай”, “Батцэцэрлэгжилт”, “Өв-эхлэл өнгө”, “Их говийн төгөл” ХХК зэрэг 6 аж ахуйн нэгж, байгууллагад 216,0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс олголоо.



Үүний үр дүнд 2021 онд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн мод үржүүлгийн 10 газарт 15 нэр төрлийн нийт 327,9 мянган тарьц, суулгац ургуулж байсан бол, 2022 онд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх 11 аж ахуйн нэгж, иргэн нэмэгдэж, мод үржүүлгийн 21 газарт 18 нэр төрлийн 2,0 сая орчим тарьц суулгац ургуулж байна.

Үүнд 2 настайгаас дээш буюу 2023 онд ойжуулалт цэцэрлэгжүүлэлтэд шилжүүлэх тарьц суулгац 340,0 мянга орчим байгаа бөгөөд 2024 оноос эхлэн жил тутам 1200,0 мянгаас дээш тооны тарьц суулгацыг нийлүүлэх боломж бүрдсэн.

Агро ойжуулалт, авто зам дагуу ногоон зурвас байгуулав.

Хархорин суманд газар тариалан эрхэлдэг 16 аж ахуйн нэгж 10 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулж, 16,0 мянган мод, Төгрөг сумын Мазарт 6 га талбайг хашиж агро ойжуулалт хийж, 1200 ширхэг мод тус тус тарьсан.

Зураг 4.5



Арвайхээр, Хужирт, Хархорин, Бүрд сумдад улсын чанартай авто зам дагуу мод тарих ажлыг эхлүүллээ.

Арвайхээр суманд улсын чанартай А301 авто замын дагуу 2,5 км урт, 15 метр өргөнтэй хамгаалалтын хашаа барьж, 3400 ширхэг мод, Хужирт сумын Рашаан сувиллын орчим “Жем-Хужирт” ХХК, Хужирт рашаан сувилал ХХК 800 метр ойн зурвас, “ӨВ-А33А” ТӨХК Бүрд сумын Шариланд “Алтан шар зам” төгөл байгуулж, 1000 ширхэг мод тарьж, улсын төсвийн хөрөнгөөр газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх

хөтөлбөрийн хүрээнд Баруунбаян-Улаан суманд элсний нүүлтээс хамгаалах 8 га ойн зурвас байгууллаа. Зорилтот жилийн хүрээнд нийт Агро ойжуулалт 12,4 га, авто зам дагуу 3,3 км ногоон зурвас байгуулаад байна.

Усалгааны систем, хамгаалалтын хашаа байгуулах технологийн оновчтой шийдлүүдийг нэвтрүүлэв.

“Хөдөө аж ахуйг дэмжих сан”-гийн хөнгөлөлтөд 2 аж ахуйн нэгж хамрагдаж, хямд өртөгтэй дуслын болон намираа усалгааны систем, усны нөөцийн сав, бусад тоног төхөөрөмжийг нэвтрүүлэв. Мөн Арвайхээр сумын “Их монгол” цэцэрлэгт хүрээлэнд 10 га-гийн дуслын усалгааны системийг тухайн сангаас хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдан авсан.

Аймгийн хэмжээгээр мод тарьсан газрын усалгаанд зориулж гүн өрмийн 16 худаг, 3 гар худаг гаргаж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл авахад нийт 514,1 сая төгрөг, ногоон байгууламжийн хашаа барих, мод тарихад 947,6 сая төгрөгийг төр, хувийн хэвшлээс зарцуулсан байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар гүйцэтгэх Мод тарих газрын хамгаалалтын хашаа барих ажлын гүйцэтгэгчээр “Их өшгөр” ХХК шалгарч, Арвайхээр сумын нийтийн эзэмшлийн талбай, Цэргийн анги, Улаанбаатар-Арвайхээрийн авто замын дагуу мод тарих 4 хэсэг талбайд 6300 метр урт хамгаалалтын хашаа барьж, уг ажилд 75,6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулав. Тухайн хашааны шонг “Арвайхээр тохижилт үйлчилгээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, хаягдал хуванцраар боловсруулан хийж, хашаажуулсан ба аймгийн хэмжээнд нийт 19 худаг, 2200 метр усалгааны систем, 27000 метр хайс хашлага шинээр хийгдсэн байна.

Сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд мод, бут тарих, мод үржүүлгийн газар байгуулах газрын байршлыг тусган батлуулж, аймгийн хэмжээнд мод, бут тариалах ажлыг зохион байгуулав.

Зураг 4.6



Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөнд 13 суманд 458,7 га газрыг мод тарих, ногоон байгууламж, мод үржүүлгийн газар байгуулах иргэн аж ахуйн нэгжид олгохоор тусгаж, 100 орчим га талбайг мод үржүүлэг, ногоон байгууламж байгуулах зориулалтаар ашигласан байна.

Аймгийн хэмжээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, бүх нийтээр мод тарих өдрүүдийн хүрээнд нийт 320,0 мянган ширхэг мод, бут тарьсан.

Нийт тарьсан модны 36,0 мянгыг айл өрх, 70,0 мянга орчмыг албан байгууллага, аж ахуйн нэгжүүд тарьж, 140,0 мянган ширхгийг төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид, 74,0 мянган ширхгийг ойжуулалт, хамгаалалтын ойн зурваст тарьж, уг ажилд нийт 492 аж ахуйн нэгж, байгууллага, 16428 иргэн оролцож, тарьсан модны амьдралтын хувь дунджаар 80,0 хувьтай ургаж байна.

Мод бут тарих ажилд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, аж ахуйн нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж ажиллав.

Зураг 4.7



Тайлант онд 474 аж ахуйн нэгж, байгууллагатай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, шинээр байгуулагдсан 31 га талбай бүхий ногоон байгууламжид 70,0 орчим мянган мод, бут тарьлаа. Гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүд ногоон байгууламжийн хашаа барих, өөрсдийн зардлаар мод тарих, тарьц суулгац нийлүүлэх, тарьсан модыг усалж арчлах, гүний худаг гаргах, бичил цэцэрлэгт хүрээлэн болон авто зам дагуу ойн зурвас байгуулав.

Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж ажилласан байгууллага, аж ахуйн нэгжүүдээс Арвайхээр сумын “Ноос ирээдүй” ХХК, Мобиком корпораци, Уянга сумын “Аум-алт” ХХК, “Аймгийн бичил уурхайн нэгдсэн холбоо”, Бат-Өлзий сумын “Их сумт хайрхан” ХХК, Хужирт сумын “Жем-хужирт” ХХК, Хайрхандулаан сумын бичил уурхайчид зэрэг олон аж ахуйн нэгж, байгууллага, иргэд мод бут тарих ажилд идэвх санаачилгатай оролцлоо.

Мод тарих газрын усалгаа, арчилгаа, хамгаалалтыг хариуцан ажиллах хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэж ажиллав.

“Ногоон ажлын байр” хөтөлбөрийн хүрээнд нийт 500 иргэнийг түр ажлын байраар хангаж, сумын ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа, модны нүх ухах ажилд 10 хоногийн хугацаатай ажиллуулав. Сумд мод тарих газрын усалгаа, арчилгаа, хамгаалалтыг хариуцан ажиллах 24 хүнийг Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоонд багтаан гэрээгээр болон ажил үүрэгт өөрчлөлт оруулах, хавсран гүйцэтгэх байдлаар шийдвэрлэж, Арвайхээр, Хархорин сумд ногоон байгууламж, тохижилт үйлчилгээ хариуцсан байгууллагад усалгаа, арчилгаа хариуцсан 30 гаруй түр орон тооны ажилтан ажиллуулж байна.

Төрийн үйлчилгээг цахимаар үзүүлэх чиглэлээр:

Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Цахим Засаглал” бодлогын хүрээнд цахим шилжилт, цахим технологи нэвтрүүлж буй төрийн байгууллагуудын үйлчилгээ, тоног төхөөрөмжүүдийг төрийн Үйлчилгээний нэгдсэн төвд суурилуулж, төрийн үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах төлбөр тооцоог хялбараар шийдэх техник, технологийг ашиглан ажиллаж байна.

Үйлчилгээний нэгдсэн төвд нэвтрүүлсэн цахим үйлчилгээ:

- ✓ Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia үйлчилгээний оператор
- ✓ Газрын харилцаа-цахим шилжилтийн E-Gazar өөртөө үйлчлэх булан
- ✓ Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн E-Khutuch өөртөө үйлчлэх булан
- ✓ Төлбөр тооцооны “Гэрэгэ” киоск машин зэргийг үйлчлүүлэгчдийн хэрэглээнд нэвтрүүлээ.

2022 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 37393 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

Зураг 4.8



Цахим хөгжил, харилцаа холбооны яам, “И-Монгол” академийн хамтарсан ажлын хэсэг 2022 оны 05 дугаар сарын 09-нөөс 13-ны өдрүүдэд Өвөрхангай аймагт ажиллаж нутгийн захиргааны 15 байгууллагын 67 үйлчилгээг E-Mongolia системд нэвтрүүлж, 332 иргэнд цахим үйлчилгээ үзүүлсэн.

Дээрх 15 байгууллагаас "E-Mongolia" системээр үйлчилгээ авах хүсэлтээ ирүүлсэн иргэдийн хүсэлтийг холбогдох хууль, тогтоомж, дүрэм журамд заасан хугацаанд нь шийдвэрлэж, цахимаар үйлчилгээ үзүүлж буй эсэхэд аймгийн Засаг даргын Тамгын газраас service.e-mongolia.mn системийг ашиглан хяналт тавин ажиллаж байна.

Өвөрхангай аймагт E-mongolia системийн хэрэглээг нэвтрүүлэх, төрийн албан хаагчид, иргэдийн мэдээллийн технологи ашиглах, чадавхыг хөгжүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулав. Цахим системд шилжсэн төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, иргэдэд төрийн үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай авах нөхцөл, боломжийг бүрдүүлэх зорилгоор "Цахим Өвөрхангай" нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, уг өдөрлөгт 17 төрийн байгууллага оролцож, цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээгээ иргэд, олон нийтэд танилцуулж, зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Зураг 4.9

E-Mongolia цахим үйлчилгээний системийг хэрхэн ашиглах талаар заавар, зөвлөгөөг өгөх, мэдээллийн технологийн ур чадварыг олгох сургалтад нийт 1000 гаруй иргэнийг хамруулав.



Аймгийн хэмжээнд E-Mongolia цахим системд 15 байгууллагын 67 үйлчилгээ нэвтэрч, төрийн үйлчилгээний операторын үйлчилгээ эрчимжүүлэн 19 сумын операторын үйлчилгээ хариуцсан албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангаж, цахимд шинээр нэвтэрч буй үйлчилгээний мэдээллийг тухай бүрд зайнаас мэдээлж, нийт 310 төрлийн 7200 цахим үйлчилгээг иргэдэд үзүүлсэн.

Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн амбулаторийн эмчийн үзлэгийн цагийг урьдчилан захиалах “CALL PRO” операторын шинэ технологийг нэвтрүүлж, 7032-3212 дугаарын утсаар ажлын өдөрт үйлчилж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 113000 иргэнд үзлэгийн цаг өгсний 81057 дугаар нь утсаар олгосон нийт үзлэгийн 71.7 хувийг эзэлж байна.

Зураг 4.10



Дэлхийн банкны санхүүжилтээр Арвайхээр, Хархорин сумдын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах “Эрчим хүчний төсөл-2” хүрээнд аж ахуйн нэгж, иргэдийн 10506 ширхэг ухаалаг тоолуур суурилуулахаас одоогийн байдлаар 1774 өрхийг ухаалаг тоолуурт шилжүүлээд байна. Эрчим хүч хэрэглэсний төлбөрийн мэдээллийг сар бүр хэрэглэгчдийн гар утсанд мессежээр илгээж байна. Эрчим хүч хэрэглэгч айл өрхүүдийн 60-70 хувь нь төлбөрөө интернэт, мобайл банк ашиглан төлж байна.

Аймгийн хэмжээнд 24 худгийг ухаалаг болгож, 24 цагийн ажиллагаатай болгов. Нийт 4600 гаруй айл өрх цахим карт ашиглаж байна.

Гэрэгэ ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, орон нутгийн төсвийн 70,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр 15 сумыг киоск машинаар хангаж, сум иргэд сум, орон нутагтаа төрийн байгууллагын 100 гаруй төрлийн үйлчилгээний төлбөр тооцоог хийх боломж бүрдэж байна.

Зураг 4.11



Өвөрхангай аймаг нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах” зорилтот жилийн хүрээнд аймгийн төвд иргэдийн амарч, зугаалах ая тухтай орчин бүрдүүлэх зорилгоор 12 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил хийгдэж байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа үүрэн холбооны оператор, байгууллагуудад энэхүү цэцэрлэгт хүрээлэнд тус бүр 350 м² талбайг хуваарилан өгч, нийгмийн хариуцлагын хүрээнд байгууллагынхаа нэртэй бичил төгөл байгуулж, WIFI орчин, утас цэнэглэх хэсэг, сүүдрэвч, сандал, орчны гэрэлтүүлэг зэрэг тухайн орчныг сайжруулах бусад тохижилтын ажлуудыг хийж, орон нутагтай хамтарч ажиллах саналыг хүргүүлсэн.

Үүний үр дүнд эхний ээлжид Мобиком корпорацаас 2000 мкв бүхий талбайд FREE WIFI үнэ төлбөргүйгээр цацаж байна.

Мөн аймгийн төв талбай, Хүүхэд, залуучуудын цэцэрлэгт хүрээлэн, төрийн байгууллагуудад иргэд олон нийтэд зориулсан утасгүй интернэтийн төхөөрөмжийг суурилуулсан.

Зураг 4.12



Мобиком корпорацаас 5,0 тэрбум төгрөгөөр Уянга, Баянгол, Өлзийт, Хужирт, Зүүнбаян-Улаан, Бүрд, Хархорин, Тарагт, Арвайхээр сумдын алслагдсан багуудад 4G сүлжээ шинээр нэвтрүүлсэн. Мөн Юнител групптэй байгуулсан гэрээний хүрээнд 8,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 23 байршилд 4G сүлжээг нэвтрүүлэх, “Юнивишн гэр хороолол” төслийн 3,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3000 айл өрхийг шилэн кабельд холбох, аймгийн Засаг даргын Тамгын газар болоод хэрэгжүүлэгч агентлагуудад өндөр хурдны шилэн кабелийг холбох саналыг тавьсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаас Өлзийт, Гучин-Ус сумын 1 дүгээр багуудад 209,0 сая төгрөгөөр, Уянга сумын төвөөс Жаргалант багийн төв хүртэл 420,0 сая төгрөгөөр 60 км урт шилэн кабель тавигдсан.

Зураг 4.13



Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазууд, үзвэр, үйлчилгээ, үзэсгэлэнт газруудын тухай цогц мэдээллийг багтаасан Uvurkhangai travel аппликэйшнийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн.

ЭрдэнэЗуу музей нь виртуал музейн тоноглолтой болж⁷, ШУТИС-ийн судлаач, эрдэмтдийн зохион бүтээсэн 10 виртуал контентыг хийж, ЭрдэнэЗуугийн анхны төрх байдлыг харуулсан 6,0 сая төгрөгийн үнэ бүхий макет, шилдэг бүтээлийн каталогийг хийж иргэдэд танилцуулсан.

⁷ <https://www.facebook.com/MinistryofEdu/videos/151483519794603>

Зураг 4.14



Дэлхийн банкны санхүүжилтээр Арвайхээр, Хархорин сумдын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэн сайжруулах “Эрчим хүчний төсөл-2” хүрээнд аж ахуйн нэгж, иргэдийн 10506 ширхэг ухаалаг тоолуур суурилуулахаас одоогийн байдлаар 1774 өрхийг ухаалаг тоолуурт шилжүүлээд байна. Эрчим хүч хэрэглэсний төлбөрийн мэдээллийг сар бүр хэрэглэгчдийн гар утсанд мессежээр илгээж байна. Эрчим хүч хэрэглэгч айл өрхүүдийн 70-80 хувь нь төлбөрөө интернэт, мобайл банк ашиглан төлж байна.

Арвайхээр сумын хэмжээнд 25 худгийг ухаалаг болгож, 24 цагийн ажиллагаатай болгов. Мөн Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Хайрхандулаан, Сант, Баянгол зэрэг сумдуудад 24 цагийн ухаалаг худаг байгуулсан. Нийт аймгийн хэмжээнд 20000 орчим айл өрх цахим карт ашиглаж байна. Мөн эдгээр усан сангуудаар халуун усыг давхар түгээж байгаад иргэд сэтгэл өндөр байгааг олон нийтээс авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн харуулж байна.

Зураг 4.15



Цахим гарын үсгийн тухай шинэчилсэн найруулга хууль 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын 16 нас хүрсэн иргэн бүрд тоон гарын үсгийг иргэний хүсэлтээр оршин суугаа газрын харьяалал харгалзахгүйгээр иргэний үнэмлэхийн санах ойд байршуулж, гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулж, аймгийн хэмжээнд 26172 иргэнд тоон гарын үсэг олгоод байна.

Газрын удирдлагын нэгдсэн системийн бүрэлдэхүүн хэсэг хаягийн мэдээллийн системийг улсын хэмжээнд шинээр нэвтрүүлж буйтай холбогдуулан аймгийн болон сумдын төв, суурин газруудад өмнө хийгдсэн хаягийн зургийг Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолд нийцүүлэн засварлах ажилд менежер программ хангамж болон хаягийн веб систем ашиглан хийсэн. Дээрх журамд нийцүүлэн шинэчилсэн хаягийг Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн төвд хаягийн мэдээллийн системд Ланд менежер программ хангамж болон хаягийн веб систем ашиглан нийт 782 гудамж болон 57 дэд гудамжийг засварлан нэр өгсөн. Мөн 1448 гудамжны эхлэл, төгсгөлийг бодуулж 10300 гаруй нэгж талбарын орц, гарцыг бодуулсан. Орон нутгийн гудамж, талбай, барилга, орон сууц, хашааг 100 хувь хаягжуулсан.

Зураг 4.16

Арвайхээр сумын теле-хяналтын камерын нэгдсэн системд 54 цэгт 138 теле-хяналтын камер хэвийн ажиллаж байгаагаас 103 ширхэг чиглэлийн камер, 28 ширхэг хөдөлгөөнт камер, 7 ширхэг автомашины дугаар таних камерыг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд ашиглаж, нийтийн эзэмшлийн зам талбай, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний соёлыг хэвшүүлэх зэргээр Үйлчилгээний нэгдсэн төвд хяналтын системийг төвлөрүүлэн хянаж байна. Камерын хяналтын системийг тогтмолжуулснаар иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл сайжирч, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, нийтийн эзэмшлийн зам талбайн эд зүйлсийг хамгаалах, автомашины хөдөлгөөнийг хянах ажилд томоохон үүрэг гүйцэтгэж, бодит үр дүнгээ үзүүлж байна.



Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр (хог хаягдлын менежмент)

Хог хаягдлыг ангилан ялгах савны жишиг загварыг боловсруулж, эх үүсвэр дээр нь ангилах ажлыг эхлүүлэв.

Гэр хорооллын айл өрхүүдийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг идэвхжүүлж, хог хаягдлын менежментийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “Өнгө нэм” төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хог хаягдлыг ангилан ялгах, хадгалах зориулалт бүхий олон ангилалтай хогийн савны жишиг загварыг 2 төрлөөр буюу гэр хороолол болон орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар гаргаж, иргэд айл өрхүүдэд сурталчилж ажиллав. Аймгийн төвийн 1383 өрх буюу нийт өрхийн 14,7 хувь ангилан ялгах хогийн савтай болж, хуванцар сав ангилах 25 ширхэг, дахивар болон энгийн хог хаягдал ангилах 14 ширхэг, хуванцар, цаас, бусад гэсэн ангиллаар 23, нийт 62 ширхэг хогийн савыг шинээр хийж, нийтийн эзэмшлийн зам, талбайд байршууллаа.

Зураг 4.17



Төвлөрсөн хогийн цэгүүдийг хашаажуулж, камержуулан талбайн хэмжээг бууруулав.

Тайлант онд төвлөрсөн хогийн цэгээ Хайрхандулаан, Бүрд, Баян-Өндөр, Төгрөг сумд шинээр хашаажуулж, Гучин-Ус, Есөнзүйл сумд камержуулснаар аймгийн хэмээнд 12 сумын төвлөрсөн хогийн цэг хашаатай, 6 сум хяналтын камертай болоод байна. Мөн сумд аюултай хог хаягдал буюу эмнэлгийн хог хаягдлыг шатаах, устгах цэгийг төвлөрсөн хогийн цэгүүд дээр байгуулж, аймгийн хэмжээнд төвлөрсөн хогийн цэгийн нийт талбайн хэмжээ 50,3 га болж өмнөх оноос 19,9 га талбайгаар буурсан.

Хархорин сум төвлөрсөн хогийн цэгийн талбайг бууруулсан байдал:

Зураг 4.18



Химийн аюултай бодисыг устгах ажлыг зохион байгуулав.

Зураг 4.19



Аймгийн хэмжээнд Ерөнхий боловсролын 24 сургуулийн химийн кабинет, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон Хужирт сумын "Жем Хужирт" ХХК-ийн лабораториудад олон жил хадгалагдаж байсан ашигладаггүй, хугацаа дууссан химийн хортой болон аюултай 1584 нэр төрлийн шингэн 407,5 литр, хатуу болон нунтаг 462,3 кг бодис, 30 тн химийн бордоог мэргэжлийн байгууллага "Түмэн эгшиг" ХХК-тай гэрээ байгуулан Улаанбаатар хот руу тээвэрлүүлж, устгуулах ажлыг 19 сумын Засаг даргын Тамгын газар, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулав.

Сумдад хог цэвэрлэгээ болон ангилах, хүлээн авах зориулалтын техник, тоног төхөөрөмжүүдийн шинэчлэл хийгдэв.

Зураг 4.20

Баян-өндөр сум орон нутгийн хөгжлийн сангийн 100,0 сая төгрөгийн хөрөнгөөр төвлөрсөн хогийн цэгийн 10 га газрын хогийг дарж булшлан, шинээр хогийн цэг байгуулах ажлыг хийж гүйцэтгэв. Хархорин, Богд, Баянгол сумд орон нутгийн хөгжлийн сангийн 140,9 сая төгрөгийн санхүүжилтээр хог тээврийн автомашин худалдан авч парк шинэчлэлт хийгдсэн.



Есөнзүйл, Гучин-Ус, Баян-Өндөр, Уянга, Бүрд, Арвайхээр сумд 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн 69,0 сая төгрөгийн хөрөнгөөр хоёрдогч түүхий эдийг нягтруулах пресслэгч төхөөрөмжийг худалдан авч, аймгийн хэмжээнд 12 сум, 19 пресслэх төхөөрөмжтэй болов.

Зураг 4.21

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг айл өрхүүдэд хэвшүүлж, дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх ажлын хүрээнд 13 суманд хоёрдогч түүхий эд хүлээн авах 28 цэг байгуулагдаж, 301,8 тн дахивар хаягдлыг цуглуулан аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг “Эко цэнэ”, “Цэмцгэр” төвүүд болон Улаанбаатар хот руу нийлүүлсэн.



Санаачилга гаргасан иргэн, төрийн бус байгууллагуудтай хамтарч аян, бусад арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллав.

Зураг 4.22

Аймаг дахь Монгол банкны хэлтсээс санаачилсан “Дэлхийн хуримтлалын өдөр-2022” аяны хүрээнд иргэд, сурагчдын дунд “Хаягдлыг ангилж хуримтлал болгоё”, байгальд ээлтэй бүтээгдэхүүнээр “Уут сав зохион бүтээе”, “Супер анги” шалгаруулах уралдаануудыг Боловсрол, шинжлэх ухааны газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар хамтран зохион байгуулав. Тус арга хэмжээнд 14 сумын 2000 сурагч, иргэд хамрагдаж, 5,5 тонн хог хаягдлыг ангилан ялгаж дахивар хүлээн авах цэгүүдэд тушаасан.



Мөн уул овоо, гол горхи, булаг, шанд, нуур тойрмын хог хаягдлыг цэвэрлэх, байгаль дэлхийгээ хүндлэн дээдэлж ирсэн ардын уламжлалт зан үйлийг түгээн дэлгэрүүлэх зорилготой “Тольт Очирт ба түүний нөхөд” групптэй хамтран ажиллаж, 10 сумын 56 уул овооны хадаг, цаасан мөнгө, архины шил бусад ахуйн хог хаягдлыг цэвэрлэв.

Малын сэг зэмийн устгал гол ус, булаг шанд, овоо даваа, бэлчээр дагуух хог хаягдлыг цэвэрлэх чиглэлээр нийт 55 аян зохион байгуулж, 497,5 тн хог хаягдлыг цэвэрлэж, хогийн цэгт төвлөрүүлсэн.

Олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтарч ажиллав.

Зураг 4.23

Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй Арвайхээр сумын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслөөр Арвайхээр суманд пүү болон хоёрдогч түүхий эд хүлээн авах 5 цэгийг шинээр байгуулж, “Арвайхээр тохижилт үйлчилгээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт хүлээлгэн өгөв. Уг төслийн хүрээнд бичил тэтгэлэг зарлагдаж, “Эрүүл амьдрал”, “Үнсэн блок үйлдвэрлэх”, “Хаягдал сүүний савыг дахин ашиглах” зэрэг өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг иргэдийн төслүүдэд тус бүр 5000 ам.доллар, Арвайхээр тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит аж ахуйн



тооцоот үйлдвэрийн газрын “Арвайхээр суманд ногоон ажлын байр бий болгох, хаягдал хуванцар сав, гялгар уутыг дахин боловсруулж, хашааны шон, нүхэн жорлонгийн кольцо зэрэг нийгмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх” төсөлд 15,000 ам.долларын тэтгэлгийг тус тус олгоод байна. Мөн тус төслийн хүрээнд “Хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги төлөвлөгөө”-г аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09/09 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Бүх нийтийн цэвэрлэгээг улирал бүр зохион байгуулав.

Аймгийн хэмжээнд бүх нийтийн хог цэвэрлэгээ болон төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг ангилан ялгах нийтийг хамарсан ажлын хүрээнд 400 түр ажлын байр бий болж, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас 160,0 сая төгрөг зарцуулсан.

Зураг 4.24

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Онги-Тааз голын сав газрын захиргаа, Зэвсэг хүчний 256 дугаар анги хамтран 161 уст цэг болон гадаргын усны ойр орчмыг цэвэрлэх ажлыг 2 удаа зохион байгуулж, Орхон, Онги, Таац, Дайрга, Ар-Агуйн гол, Найман нуур, Ногоон нуур, Таацын цагаан нуур, Хүрэмт нуур орчмын хог хаягдлыг цэвэрлэж, нийт 85,1 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгүүдэд хүргэж ажилласан.



Мөн аймгийн хэмжээнд бүх нийтийн их цэвэрлэгээг улирал бүр зохион байгуулж, 2022 онд нийт 4 удаагийн их цэвэрлэгээгээр давхардсан тоогоор 36659 иргэн оролцож, 7096 тн хог хаягдлыг цэвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт хүргэх ажлыг зохион байгуулж ажилласан.

Дүгнэлт

-Иргэд, албан байгууллагуудын мод бут тарих, арчилж, ургуулах хандлага, мэдлэг чадвар дээшилсэн.

-“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ажлын гол бэлтгэл болох мод үржүүлгийн газруудын хүчин чадал 6 дахин нэмэгдэж нийт 2,0 сая тарьц суулгацын нөөц бүрдсэн.

-Төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ 2021 оны суурь түвшин 145 га-аас 31га (17,6хувь) талбайгаар нэмэгдэж 176 га-д хүрсэн.

-Хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав, ариун цэврийн байгууламжийн жишиг загварыг боловсруулж нэвтрүүлж эхлүүлсэн.

-Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах талаар иргэдийн идэвх санаачилга, хандлага сэтгэхүйд эерэг өөрчлөлт гарч байгаа нь ажлын гол үр дүн гэж үзэж байна.

Зөвлөмж

Цаашид байгууллага, аж ахуйн нэгж, иргэн бүр урд жилүүдэд тарьсан мод, бут, ногоон байгууламжаа арчилж, усалж, ургуулж нэмж мод бут тарих, хог хаягдлаа ил задгай хаяхгүй байх, гарсан хог хаягдлаа эх үүсвэр дээр ангилан, ялгаж зохих цэгт нь хүргүүлж хэвших шаардлагатай байна. Үүнд:

-Сумд мод тарих газрыг газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөндөө тусгаж ажиллах;

-Тарьсан модны усалгаа, арчилгааг хэрхэн шийдэж авч явах тал дээр онцгой анхаарах;

-Жил бүр тарьсан модны тооллого зохион байгуулж амьдралтын хувийг үнэн зөв тодорхойлж байх;

-Сумын төсөвт болон хувийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд эх үүсвэр дээр нь ангилан ялгах савыг нэг бүрчлэн байршуулах;

-Ангилсан дахивар хог хаягдлыг аймаг, орон нутгийн дахивар хүлээн авах цэгүүдэд хүргэх ажлыг тодорхой горимтой болгож тухайн үйл ажиллагааг тогтмолжуулах;

-Сум бүр дахивар хог хаягдлыг нягтруулж пресслэх тоног төхөөрөмжтэй болох, тухайн төхөөрөмжийг хариуцах ажиллах хүчний асуудлыг шийдвэрлэх;

-Төвлөрсөн хогийн цэг дээр байгуулсан аюултай хог хаягдлыг устгах цэгт аюултай хог хаягдлыг Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам"-ийн дагуу устгаж хэвших;

-Ард иргэд, хүүхэд багачуудад хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, иргэдийн зөв дадал хэвшилтэй холбоотой сургалт, нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, гарсан саналыг тусган Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хугацаанд нь байршуулж, аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 1/33 дугаар албан бичгээр зөвлөлийн хурлын тэмдэглэл, танилцуулгын хамт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн www.unelgee.gov.mn цахим санд 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр байршуулж, баталгаажуулав.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 81,2, Хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг 91,0 хувийн хэрэгжилттэй үнэлснийг хурлын тэмдэглэл, аймгийн Засаг даргын албан бичгээр баталгаажуулан Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний хөгжлийн газарт хугацаанд нь тайлагнасан байна.

Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гэрээнд заасан хугацаанд төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд хугацаанд нь байршуулав.

Аймгийн Засаг дарга түүний Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тоон мэдээллээр илэрхийлж болох арга хэмжээнүүдийг суурь үзүүлэлтийг зорилтот болон хүрсэн түвшинтэй харьцуулах замаар, тоон үзүүлэлтээр харьцуулах боломжгүй арга хэмжээг дүгнэхдээ чанарын шалгуур үзүүлэлтээр тооцож дүгнэсэн.

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар хавсралтын дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ, Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээний үзүүлэлтээр нэгтгэн дүгнэж ерөнхий үнэлгээг 96,32 хувь буюу 4,8 оноотойгоор тайлагнаж байна.

Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээнд Шударга байдлын түвшний үнэлгээ, Хэрэглэгчийн үнэлгээ нь судалгааны байгууллагуудын үнэлгээгээр тооцогдох тул нэгдсэн үнэлгээнд оруулж тооцоогүй болно.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР